



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот


Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шадар сайд, байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаалын 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цацрагийн осол, хордлогын үед мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллах заавар"-ыг нэгдүгээр, "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах заавар"-ыг хоёрдугаар, "Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед хүнсний бүтээгдэхүүн, ус, хөрс, арчдаст хийх лабораторийн шинжилгээний үзүүлэлт, баталгаажуулах лабораторийн нэрс"-ийг гуравдугаар, "Хилийн нэвтрэх цэгийн тусгаарлах өрөөний зохион байгуулалт, тавигдах шаардлага, шаардлагатай тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, эмийн жишиг жагсаалт"-ыг дөрөвдүгээр, "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг"-ийн загварыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зааврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналтын газар, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга нар, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ерөнхий захиралд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Ч.Энхбат/-т тус тус даалгасугай.

3. Зааврыг ажилтнуудад сурталчлан, сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналтын газрын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ЦАГААНХҮҮ

ЦАЦРАГИЙН ОСОЛ, ХОРДЛОГЫН ҮЕД МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАН АЖИЛЛАХ ЗААВАР

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Цацрагийн осол, хордлогын үед тэргүүлэх байгууллагаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар ажиллана. Хамтрагч байгууллагаар ЗТХЯ, ЭМЯ, ОБЕГ, ТЕГ, ЦЕГ, НЭМҮТ, УЦУОШГ, Гаалийн төв лаборатори, УМЭАЦТЛ, нутгийн захиргааны болон бусад холбогдох байгууллагууд, дэмжлэг үзүүлэх байгууллагаар УОК, Сангийн яам, ХЗДХЯ, БОАЖЯ, БХЯ тус тус ажиллана.

ХОЁР. НЭР ТОМЪЁО

2.1. “Ионжуулагч цацраг” гэж шууд болон шууд бус замаар бодис, биологийн биет дотор хос ион үүсгэх цацрагийг;

2.2. “Цацрагийн үүсгүүр” гэж цөмийн төхөөрөмжөөс бусад цацрагийн шарлага үүсгэгч цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацраг гаргагч аливаа багаж хэрэгслийг;

2.3. “Биет хамгаалалт” гэж Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай Венийн конвенцийн дагуу цөмийн материал болон цөмийн төхөөрөмж рүү зөвшөөрөлгүй этгээд нэвтрэн орохоос урьдчилан сэргийлсэн арга хэмжээ буюу зохион байгуулалтын нэгдсэн системийг;

2.4. “Шарлага” гэж цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн үүсгүүрээс хүнд үзүүлэх нөлөөллийг;

2.5. “Тун” гэж ионжуулагч цацрагаас бие махбодид шингээгдсэн энергийн хэмжээгээр тодорхойлогддог цацрагийн шарлагыг илэрхийлэх хэмжигдэхүүнийг;

2.6. “Гадаргуугийн бохирдлын байж болох хэмжээ” гэж цөмийн цацрагийн тунгийн байж болох хэмжээнээс тооцоолж, цацраг идэвхт задгай бодистой ажиллагчдын арьс, хувцас, ажлын байр, тээврийн хэрэгслийн гадаргад байж болох бохирдлыг нормчилсон хэмжээ.

ГУРАВ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

3.1. Цацрагийн осол, хордлогын талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн анхны мэдээг хүлээн авсан ажилтан 10 минутын дотор энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах заавар”-ын “Схем 1”-ээр мэдээг дамжуулна.

3.1.1. Мэдээг хүлээн авсан нэгжийн удирдлага хариуцсан чиглэлийн улсын байцаагчид нягталж баталгаажуулах үүргийг 10 минутын дотор өгнө.

3.1.2. Мэдээг баталгаажуулахдаа цацрагийн хордлого, цацрагийн бохирдол, цацраг, цацраг идэвхт бодис алдагдах, үйлдвэр, зам тээврийн осол, үйлдвэрийн томоохон осол гарсан эсэх зэрэг шалгууруудыг тодруулна.

3.1.3. Энэхүү зааврын 3.1.2-д заасан шалгуурын нэгээс дээш асуултад “тийм” эсвэл “мэдэхгүй” “тодорхойгүй” гэсэн тохиолдолд үйл явдал гэж үзэн баталгаажуулсан даруйд нэгжийн удирдлагад эргэж мэдэгдэж, Шадар сайд, байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн “Үйл явдлын мэдээг бүртгэж, мэдээлэх хуудас” хүснэгт 1-ийн дагуу үйл явдлыг салбар хоорондын цахим мэдээллийн сан /цаашид EBS програм (Event based surveillance-үйл явдалд суурилсан тандалт) гэх/-д 2 цагийн дотор бүртгэж, оруулна.

3.2. Цацрагийн осол, хордлогын талаарх анхны мэдээллийг EBS програмаас хүлээн авсан шуурхай мэдээлэл хариуцсан ажилтан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах заавар”-ын “Схем 2”-ын дагуу мэдээ, мэдээллийг дамжуулна.

3.2.1. Шуурхай мэдээлэл хариуцсан ажилтан EBS програмд шинээр бүртгэгдэж байгаа мэдээллийг тухай бүрт нь салбарын хэмжээнд мэдээлж ажиллана.

3.2.2. Хамтрах байгууллагуудад “Цөмийн болон цацрагийн осол, хордлогын үед хамтрах байгууллагуудад мэдээлэл дамжуулалт” схем 1-д заасны дагуу мэдээллийг дамжуулж, удирдан зохицуулна.

3.2.3. Мэдээлэл хүлээн авсан ажилтан шаардлагатай тохиолдолд мэдээллийн нууцлалыг хадгалж, ажиллана.

3.2.4. EBS програмд мэдээллийг оруулснаас хойш 6 цагийн дотор Олон улсын эрүүл мэндийн төвийн үндэсний зохицуулагч байгууллага болох Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс эрсдэлийн үнэлгээ хийх тэргүүлэх байгууллагаар сонгосон дохиог хүлээн авна.

**ЦАЦРАГИЙН ОСОЛ, ХОРДЛОГЫН МЭДЭЭГ БҮРТГЭЖ,
МЭДЭЭЛЭХ ХУУДАС**

Хүснэгт 1

1	Үйл явдлын төрөл	☐ Цацрагийн хордлого ☐ Цацрагийн бохирдол ☐ Цацраг, цацраг идэвхт бодис алдагдах ☐ Үйлдвэр, зам тээврийн осол ☐ Үйлдвэрийн томоохон осол ☐ Бусад
2	Үйл явдал мэдээлэгдсэн огноо	Он... сар ...өдөр ... цаг...мин
3	Эх сурвалж	☐ Байгууллага ☐ Иргэн ☐ Интернет мэдээлэл ☐ Телевиз ☐ Радио ☐ Сонин хэвлэл ☐ Салбарын мэргэжилтэн ☐ Лаборатори ☐ Бусад
4	Үйл явдлыг мэдээлсэн	Байгууллага, мэргэжилтний нэр, утас
5	Үйл явдал хаана болсон	Google map
6	Үйл явдал эхэлсэн огноо	Он...сар....өдөр...цаг...мин
7	Өртсөн: ☐ Хүний тоо ... ☐ Малын тоо... ☐ Амьтны тоо... ☐ Орчин (газар нутаг) Талбайн хэмжээ ... ☐ Объект...	
8	Нас барсан: ☐ Хүний тоо ... Хорогдсон: ☐ Малын тоо ... ☐ Амьтны тоо ... Эвдэрсэн, сүйрсэн: ☐ Объектын тоо ...	
9	Лабораторийн шинжилгээнд дээж/сорьц авсан эсэх:	☐ Тийм ☐ Үгүй
10	Дээж/сорьцын төрөл:	
11	Лабораторийн шинжилгээний дүн:	
12	Үүсгүүрийн тунгийн чадал: (мк ³ в/цаг)	
13	Цацрагийн үүсгүүрийн нэр, төрөл, серийн дугаар, тусгай зөвшөөрлийн дугаар:	
14	Мэдээлсэн:	Байгууллага Албан тушаал Нэр Гарын үсэг

**ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН ОСОЛ ХОРДЛОГЫН ҮЕД ХАМТРАХ
БАЙГУУЛЛАГУУДАД МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАЛТ**



ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

4.1. Цацрагийн осол, хордлогын үед EBS програмаас Мэргэжлийн хяналтын байгууллага эрсдэлийн үнэлгээг тэргүүлж хийх “**дохио**” ирмэгц “Цөмийн болон цацрагийн ослын үед түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээ хийх алгоритм”-ын дагуу салбар хоорондын хамтарсан эрсдэлийн үнэлгээг хийж, EBS програмд оруулна.


4.2. Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээгээр “бага” гэж үнэлэгдэж, явцын үнэлгээгээр 14 хоногийн хугацаанд эрсдэлийн түвшин нэмэгдээгүй бол хийсэн ажлын тайланг хамтрагч байгууллагуудаас авч нэгдсэн тайлан бичиж, EBS програмд оруулна.

4.3. Эрсдэлийн түвшингээс хамааран дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.3.1. Эрсдэлийн түвшин “дунд”, “өндөр” үед эрсдэлийн явцын үнэлгээ хийхэд шаардлагатай бол бусад салбар* хоорондын байгууллагыг татан оролцуулна.

4.3.2. Эрсдэлийн түвшин “маш өндөр” үед явцын үнэлгээ хийх үндэсний түвшний өргөтгөсөн багийг салбар хоорондын байгууллагын ТУТ-ны төвийн бүрэлдэхүүнээс бүрдүүлж ажиллана.

ЦАЦРАГИЙН ОСОЛ, ХОРДЛОГЫН ҮЕД ТҮРГЭВЧИЛСЭН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЛГОРИТМ



4.4. Түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээ хийхэд хүснэгт 2-д заасан шалгуур үзүүлэлтийг ашиглана.

ТҮРГЭВЧИЛСЭН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 2

Ослын ангилал	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
5 дугаар ангиллын осол	Хүн ам, хүрээлэн буй орчинд нөлөөлж болохуйц?	Энэ бүлэгт хөрш зэргэлдээх улс оронд гарсан ослын үр дагавар, агаарын бохирдол, улсын хилээр оруулах хүнсний бүтээгдэхүүн, тухайн бүс нутагт байсан зорчигчид, ачаа тээшний бохирдол зэргээр хүн ам, хүрээлэн буй орчинд нөлөөлөх эсэх?
4 дүгээр ангиллын осол	Хариу арга хэмжээ авах чадавхитай юу?	Тухайн аймаг орон нутгийн мэргэжлийн төв байгууллагууд, тухайн үүсгүүрийг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага нь хариу арга хэмжээ авах чадавхитай эсэх?
3 дугаар ангиллын осол	Тухайн байгууллага хариу арга хэмжээ авах чадавхитай юу?	Аж үйлдвэрийн салбарт цацрагийн үүсгүүр хэрэглэгч байгууллагууд, түүнтэй ижил төстэй өндөр эрсдэл бүхий үүсгүүр хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага нь өөрсдийн Болзошгүй ослын төлөвлөгөө, нөөц хүч хэрэгслийн хүрээнд хариу арга хэмжээ авах чадавхитай эсэх?
2 дугаар ангиллын осол	Хариу арга хэмжээ авах чадавхитай юу?	Судалгааны реактор бүхий байгууламжууд, түүнтэй ижил төстэй байгууламжид гарсан осолд хариу арга хэмжээ авах чадавхитай эсэх?
1 дугаар ангиллын осол	Атомын цахилгаан станц, түүнтэй ижил төстэй байгууламжууд дээр гарсан осол.	

5.5. Түргэвчилсэн эрсдэлийн үнэлгээ хийхэд ОУАЭА-аас гаргасан Техникийн баримт бичиг 953-д заасны дагуу цацрагийн гамшиг, ослын үзүүлэх хор уршиг, аюулын зэрэглэл, хамрах хүрээ далайцаас шалтгаалсан 5 ангиллыг мөрдлөг болгоно. Үүнд:

5.5.1. *Маш Өндөр*/ 1-р ангилал: Атомын цахилгаан станц, түүнтэй ижил төстэй байгууламжууд дээр (маш бага магадлал бүхий үйл явдлууд) сайтын дотор болон гадна хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ноцтой нөлөөллийг үүсгэх боломжтой ослоуд хамаарна.

5.5.2. *Маш Өндөр*/ 2-р ангилал: Судалгааны реакторын төрлийн байгууламжууд, түүнтэй ижил төстэй байгууламжид гарсан осол, байгууламжийн дотор болон гадна хүнийн эрүүл мэнд хүрээлэн буй орчинд нөлөөлөх боломжтой, хүн амыг цацрагийн шарлага авахаас сэргийлж олон улсын стандартын дагуу яаралтай хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагатай.

5.5.3. *Өндөр*/ 3-р ангилал: Аж үйлдвэрийн салбарт цацрагийн үүсгүүр хэрэглэгч байгууллагууд, түүнтэй ижил төстэй байгууламжид хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн зэрэглэл нь байгууламжийн гадна талд эрсдэлгүй боловч үйл ажиллагааны дотоод хэсэгт цацрагийн аюул үүсгэх. Энэ үед цацрагтай ажиллагчдын эрүүл мэндэд аюул учруулах нөхцөл бүрдэх учир энэ бүлгийн хүрээнд галаас хамгаалах, аврах анги, цагдаа, эмнэлгийн багийн тусламж үйлчилгээ шаардлагатай ба хэрэгжүүлэх арга хэмжээ, бэлэн байдлын талаар ослын төлөвлөгөөнд тусгах шаардлагатай.

5.5.4. *Дунд*/ 4-р ангилал: Урьдчилан тооцоолоогүй байршилд цөмийн болон цацрагийн яаралтай хамгаалалт, хариу арга хэмжээ авах шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа. Зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл

ажиллагаа эрхлэх, цацрагийн үүсгүүр алдагдах, зөөврийн цацрагийн үүсгүүрүүдийг ашиглах, тээвэрлэх явцад гарсан ослоуд хамаарна. Аюулын ангилал IV нь бүх улс орон, харъяалалд хамаарах аюулын хамгийн бага түвшинг илэрхийлнэ.

5.5.5. /Бага/ 5-р ангилал: Улс орны хилийн гаднах нутаг дэвсгэрт 1, 2 дугаар бүлэгт хамаарах цацрагийн ослын үеийн нөхцөл байдлыг хамруулах. Энэ бүлэгт хөрш зэргэлдээх улс оронд гарсан ослын үр дагавар, агаарын бохирдол, улсын хилээр оруулах хүнсний бүтээгдэхүүн, тухайн бүс нутагт байсан зорчигчид, ачаа тээшний бохирдол гэх мэт.

ТАВ. ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Удирдлага, зохион байгуулалт

5.1.1. Цацрагийн осол, хордлогын үед хариу арга хэмжээг Тохиолдлын удирдлагын тогтолцоо /ТУТ/-ны бүрэлдэхүүнээр хэрэгжүүлнэ.

5.1.2. ТУТ-ны бүрэлдэхүүн нь зохицуулагч, менежер, хариу арга хэмжээний баг, эрсдэлийн мэдээлэл харилцааны баг, санхүү, нөөцийн багаас бүрдэх ба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.2.1. Зохицуулагчийн үүрэг

5.1.2.1.1. Зохицуулагч нь төвийн түвшинд МХЕГ-ын дарга, нэгжийн түвшинд НМХГ-ын дарга, аймгийн МХГ, ХМХА-ны дарга байна.

5.1.2.1.2. Зохицуулагч нь хариу арга хэмжээний үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар ханган, багуудын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

5.1.2.1.3. Менежерийг чиглүүлж, бодлогын дэмжлэг үзүүлэх;

5.1.2.1.4. Байгууллага, нэгжийг идэвхижүүлэх;

5.1.2.1.5. Эрсдэлийн мэдээлэл харилцааны үйл ажиллагааг чиглүүлэх;

5.1.2.1.6. Үүссэн нөхцөл байдалтай холбоотой үнэн зөв мэдээллээр салбар хоорондын байгууллагыг шуурхай хангаж, үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх;

5.1.2.1.7. Багийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэх, багасгах шийдвэрийг гаргах;

5.1.2.1.8. Хариу арга хэмжээний үнэлгээний хурлыг удирдан зохион байгуулах;

5.1.2.1.9. Хариу арга хэмжээний тайланг хянаж, баталгаажуулах.

5.1.2.2. Менежерийн үүрэг

5.1.2.2.1. Менежер нь төвийн түвшинд МХЕГ-ын ЦЦАБХ-ын газрын дарга, нэгжийн түвшинд аймаг, нийслэлийн МХГ-ын холбогдох хяналтын хэлтсийн дарга, ХМХА-ны хяналт шалгалтын хэлтсийн дарга байна.

5.1.2.2.2. Менежер нь багуудын үйл ажиллагааг тодорхойлон уялдуулах;

5.1.2.2.3. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтоож, хариу арга хэмжээг төлөвлөн, удирдах;

5.1.2.2.4. ТУТ-ны бүрэлдэхүүнийг хянаж, ажилтан эзгүй тохиолдолд орлон ажиллах хүнийг зохицуулагчтай зөвшилцөн томилох;

5.1.2.2.5. Багийн бүрэлдэхүүнд орж ажиллаж буй улсын байцаагч, ажилтны үүргийг тодорхойлох, удирдан чиглүүлэх, хяналт тавих;

5.1.2.2.6. Бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

5.1.2.2.7. Олон нийтэд мэдээлэх мэдээллийн тоймыг хянан баталгаажуулах, мэдээлэх;

5.1.2.2.8. Шуурхай хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох, хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.2.2.9. Салбар хоорондын байгууллагуудтай хамтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

5.1.2.2.10. Хариу арга хэмжээний тайланг хянаж, зохицуулагчид танилцуулах.

5.1.2.3. Хариу арга хэмжээний багийн үүрэг

5.1.2.3.1. Цацрагийн осол, хордлогын үед МХЕГ тэргүүлэх байгууллагаар ажиллаж, ослын ангилал бүрт тохирсон хариу арга хэмжээг хамтрагч байгууллагуудтай хамтран хүснэгт 3-ын дагуу авч хэрэгжүүлнэ.

ОСЛЫН АНГИЛАЛ БҮРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 3

I, II ангиллын осол "Маш өндөр"	
Үйл ажиллагааг эрхлэгч	Ослын бүс дэх ажилтнууд
Шуурхай авах арга хэмжээ: ослыг ангилах; ослын түвшнийг бууруулах; тухайн улсад олон улсын зөвлөмжид нийцсэн хамгаалах арга хэмжээ авахыг санал болгох, мэдээлэх; тухайн талбайг хамгаалах; тусламж авах; байгууламжийн ойролцоо хүрээлэн буй орчны хяналт хийх; тухайн газрын албаны хүмүүс олон нийтийг мэдээлэлтэй байхад туслах	Шуурхай авах арга хэмжээ: ослын бүсэд хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх; хүнсний бүтээгдэхүүнд хязгаарлалт тавих төлөвлөлтийн радиус доторх бохирдсон хүнсний бүтээгдэхүүний хэрэглээнд хяналт тавих; тусламж үйлчилгээг үзүүлэх; бохирдсон буюу хэт их шарлагад өртөгсдөд эмнэлгийн тусламжийг үзүүлэх; олон нийт, хэвлэл мэдээлэлд эрсдэлийн талаар болон авах арга хэмжээний талаар ойлгомжтой байдлаар танилцуулах; олон нийтийн зүй бус ажиллагааг хянах, түүнд хариу арга хэмжээ авах
III ангиллын осол "Өндөр"	
Үйл ажиллагааг эрхлэгч	Байгууламжтай шууд харьцдаг ажилтнууд
Шуурхай авах арга хэмжээ: ослыг ангилах; зэргийг үнэлэн, ослын бүс тогтоож хамгаалалтад авах; тухайн газрын албаны хүмүүст мэдээлэх; тусламж авах; Байгууламжийн ойролцоо хүрээлэн буй орчны хяналтыг хийж тухайн газар эрсдэлгүй гэсэн баталгааг гаргах; тухайн газрын албаны хүмүүс олон нийтийг мэдээлэлтэй байхад туслах	Тусламжийн үйлчилгээг шуурхай үзүүлэх арга хэмжээ: бохирдсон буюу хэт их шарлагад өртсөн хохирогчдод эмнэлгийн тусламжийг үзүүлэх; цацрагийн тархалтын бүсийг тогтоох; олон нийт, хэвлэл мэдээлэлд эрсдэлийн талаар болон авах арга хэмжээний тухай мэдээлэх; олон нийтийн зүй бус ажиллагааг хянах
IV ангиллын осол "Дунд"	
Үйл ажиллагааг эрхлэгч (аюултай зөөврийн үүсгүүр)	Тухайн газрын ажилтнууд (үндэсний түвшин)
Шуурхай авах арга хэмжээ: тухайн газрын албаны хүмүүст эрсдэлийн талаар мэдээлэх, ослын түвшнийг бууруулах, ойролцоох хүмүүсийг хамгаалах арга хэмжээг авах, ослын үнэлгээ хийх; Хэрвээ шаардлагатай бол тухайн газрын албаны хүмүүст техникийн тусламж үзүүлэх	Авах арга хэмжээ: цацрагийн ослыг илрүүлэн, хариу арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд эмнэлгийн эмч нар, хаягдал металл хүлээн авдаг, худалдаалдаг төвүүд болон хилийн хяналтын газар мэдээлэх; цацрагийн ослыг үнэлэх, хариу тусламжийг авах, олон улсын зөвлөмжид нийцсэн хамгаалалтын арга хэмжээг шуурхай авах, олон нийт, хэвлэл мэдээлэлд эрсдэлийн талаар болон авах арга хэмжээний талаар ойлгомжтой байдлаар танилцуулах; улс хоорондын ослыг ОУАЭА-д мэдээлэх; хариу авах арга хэмжээний талаар ОУАЭА-д мэдээлэх; шаардлагатай бол ОУАЭА-аас тусламж хүсэх
V ангиллын осол "Бага"	
Хүнсний бүтээгдэхүүнд хязгаарлалт тавих төлөвлөлтийн радиус доторх хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон фермерүүд	Тухайн газрын ажилтнууд (Хүнсний бүтээгдэхүүнд хязгаарлалт тавих төлөвлөлтийн радиус)
Бохирдсон хүнсний бүтээгдэхүүн, ундны усанд хяналт тавих болон хүнсний бүтээгдэхүүн, ундны усан хангамжийг хамгаалах зорилгоор шуурхай хариу арга хэмжээ авах албан ёсны зааварчилгаа боловсруулан гаргах ажиллагааг шуурхай явуулах	Олон улсын стандартад нийцүүлэн бохирдсон хүнсний бүтээгдэхүүн, ундны усанд хяналт тавих болон хүнсний бүтээгдэхүүн, ундны усан хангамжийг хамгаалах зааварчилгааг боловсруулан гаргах

5.1.2.3.2. Хамтрагч болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд хүснэгт 4-д заасан төлөвлөгөөний дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь цацрагийн осол, хордлогын үед мэргэжил арга зүй, нөөц хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлж, шуурхай хариу арга хэмжээг хамтран төлөвлөх;

Онцгой байдлын ерөнхий газар нь ослын нөхцөл байдалд үндэслэн шуурхай хариу арга хэмжээг хамтран төлөвлөх, "Цацрагийн ослын үед ажиллах аюулгүй ажиллагааны заавар"-ын дагуу Цацрагийн осол, хордлогын үед хор уршгийг арилгах, аврах, эрэн хайх, тусгай цэвэрлэгээний бүлгийг томилж ажиллуулах;

Цагдаагийн ерөнхий газар нь цацрагийн осол, хордлогын үед ослын голомт, хязгаарлах бүсийг хамгаалалтад авч, нэвтрэх эрхийг хязгаарлах, цацрагийн үүсгүүр, цөмийн материалын хууль бус үйл ажиллагаанаас сэргийлэх;

Тагнуулын ерөнхий газар нь ослын шалтгааныг тодорхойлох, холбогдох мэдээ, мэдээллээр хангах;

Эрүүл мэндийн яам нь эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд холбогдох арга хэмжээг авч, туслалцаа үзүүлэх;

Ус, цаг уур, орчны шинжилгээний газар нь цацрагийн бохирдол үүссэн тохиолдолд агаарын тандалтын бүлэгтэй хамтарч, холбогдох мэдээ, мэдээллээр хангах, гадаад орчны цацрагийн хяналтын сүлжээг идэвхижүүлэх;

Зам тээвэр хөгжлийн яам нь цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх явцад гарсан ослын үед хамтарч оролцох;

Гаалийн төв лаборатори, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь шаардлагатай тохиолдолд лабораторийн бүлэгтэй хамтарч шинжилгээ хийж ажиллах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

Хүснэгт 4

Цацраг, цацраг идэвхт бодис алдагдах

№	Хийгдэх ажил	Ц (Хугацаа) (цаг:минут)	Удирдан зохицуулах байгууллага	Дэмжлэг үзүүлэх байгууллага
1	Цацрагийн аюулын талаар зарлан мэдээлэл хүргэх	Ц+00:05-00:50	МХЕГ	ЦЕГ, ЦЭК
2	Цацраг идэвхт бодис алдагдсан аюулын нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах	Ц+00:1:40	МХЕГ	ЭМЯ, БХЯ, ОБЕГ, ТЕГ, ЦЕГ, ЦЭК
3	Шуурхай бүлэг томилох	Ц+00:55	Улсын алба,	
4	Тусгай цэвэрлэгээний бүлэг томилон ажиллуулах	Ц+00:50-2:00	ОБЕГ	МХЕГ, БХЯ, ЭМЯ
5	Аврах, сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулах	Аврах ажиллагааны журмаар	МХЕГ	ОБЕГ, Улсын албад
6	Хохирлын үнэлгээ гаргах	Тусгай төлөвлөгөөгөөр	МХЕГ	Ажлын хэсэг
7	Сэргээн босгох ажлыг үе шат, дэс дараатай зохион байгуулах	Тусгай төлөвлөгөөгөөр	МХЕГ	ОБЕГ, МХЕГ, Улсын албад
8	Олон улсын байгууллагаас хүсэх тусламж, дэмжлэгийг зохицуулах	Тусгай төлөвлөгөөгөөр	МХЕГ	УОК, ЦЭК, МБЦХУАлба,

Үйлдвэр, зам тээврийн осол

№	Хийгдэх ажил	Ц (Хугацаа) (цаг:минут)	Удирдан зохицуулах байгууллага	Дэмжлэг үзүүлэх байгууллага
1	Голомтод "Аврах бүлэг" томилон ажиллуулах	Ц+00:40	МХЕГ	ОБЕГ, МХЕГ, ЦЕГ, ЭМЯ
2	Шаардлагатай тохиолдолд "Шуурхай бүлэг" томилох	Ц+00:55	УОК	УУЯ, ХХААЯ, БХЯ, ОБЕГ, ЦЕГ, МХЕГ
3	Аврах, гал унтраах, сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах	Ц+00:55-с хойш	МХЕГ	ОБЕГ, Улсын албад
4	Хохирлын үнэлгээ гаргах	Ц+01:00-72:00	УОК	Ажлын хэсэг
5	Үйлдвэрийн томоохон осол болсон үед сэргээн босгох ажлыг тухайн үйлдвэртэй хамтран үе шат, дэс дараатай зохион байгуулах	Тусгай төлөвлөгөөгөөр	УОК	Ажлын хэсэг

5.1.2.3.3. Цацрагийн хяналтын алба нь хүснэгт 5-д заасан бүрэлдэхүүнтэйгээр ажиллана.

Мэргэжлийн ангиуд нь дээжлэлтийн, ариутгал, халдваргүйжүүлэлтийн, хэмжилтий, лабораторийн багаж тоног төхөөрөмжийн гэсэн туслах бүлгүүдтэй байна.

Мэргэжлийн ангиудаар цацрагийн осол, хордлогын шалтгаан, нөхцөлийг судлуулан холбогдох хэмжилт хийлгэж, хяналтын болон ажиглалтын бүсийг тогтооно.

Осол, хордлого гарсан газар, байрлал, хугацаа, нөхцөл байдлын талаарх мэдээллээр улсын албыг шуурхай хангах, мэргэжлийн анги, ажлын хэсгүүдээр үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулна.

Шаардлагатай тохиолдолд Улсын онцгой комисс болон холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, тусламж, дэмжлэг авах ба мэргэжлийн заавар, зөвлөмж боловсруулж, Улсын алба, ЦЭК-т хандаж ОУАЭА-аас тусламж, дэмжлэг авах асуудлыг шийдвэрлүүлнэ.

**ЦАЦРАГИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ЦАЦРАГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ
МАРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Хүснэгт 5

МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН	
	Албан тушаал
Нэг. Агаарын тандалтын бүлэг	
1	МХЕГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
2	НМХГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
Хоёр. Цацрагийн хяналтын бүлэг	
3	МХЕГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч
4	НМХГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
Гурав. Изотоп тодорхойлох бүлэг	
5	НМХГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
6	МХЕГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
Дөрөв. Үүсгүүр аюулгүй болгох бүлэг	
7	НМХГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч
8	ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн шинжээч
Тав. Үнэлгээ, дүн шинжилгээний бүлэг	
9	МХЕГ-ын ЦөХХ-ийн дарга
10	ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн Чанарын менежер
Зургаа. Эмнэлгийн тусламж үзүүлэх бүлэг	
11	МХЕГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч
12	НМХГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
Долоо. Био туршилтын бүлэг	
13	ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн Шинжээч
14	ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн Шинжээч
Найм. Цацрагийн эмгэг судлалын бүлэг	
15	МХЕГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч
16	НМХГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
Ес. Дээжлэлтийн бүлэг	
17	ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн Шинжээч
18	ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн Шинжээч
Арав. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүлэг	
22	МХЕГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
23	НМХГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
Арван нэг. Хэмжилтийн бүлэг	
24	НМХГ-ын Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч
25	ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн Шинжээч
Арван хоёр. Лабораторийн бүлэг	
26	ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн Чанарын менежер
27	ХАБҮЛЛ-ийн ЦХЛ-ийн шинжээч

Цацрагийн ослын ангиллаас хамааруулан хүснэгт 6-д заасан тоогоор бүлгүүд ажиллана.

Хүснэгт 6

Цацра- гийн ослын анги лал	Шаардлагатай бүлгүүдийн тоо												
	АТБ	ЦХБ	ИТБ	ҮАББ	ҮДШБ	ЭТҮБ	БТБ	ЦЭСБ	БДБ	ДБ	АХБ	ХБ	ЛБ
I	1	6	3	1	3	1	1	1	1	6	3	3	2
II	1	3	1	1	3	1	©	©	©	2	2	2	2
III	©	1	1	1	1	©	©	©	©	1	1	1	1
IV	©	1	1	1	1	©	©	©	©	1	1	▲	1
V	©	1	2	▲	1	▲	▲	▲	▲	3	▲	▲	1

Тайлбар: © Тусламж хэрэгтэй тохиолдолд ОУАЭА-ийн Ослын байдлын хариу арга хэмжээний сүлжээ (ERNET)-нд хандах шаардлагатай,

▲ Шаардлагагүй

Цацрагийн осол, хордлогын үед ажиллах бүлгүүдийн гүйцэтгэх үүрэг

Цацрагийн осол, хордлогын үед хүснэгт 7-д заасан “Мэргэжлийн болон цацрагийн хяналтын улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-ний дагуу хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 7

№	Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хангамж
1	Ч+0-1,5 цагийн дараа	Цацрагийн осол, хордлогын талаарх мэдээллийг хүлээн авах, холбогдох албан тушаалтнуудад мэдээлэл өгнө. Аюул ослын үед ажиллах мэргэжлийн бүлэг цугларч бэлэн байдалд байна. Аюул осолд өртсөн байгууллагын цацрагийн үүсгүүрийн мэдээллээр холбогдох байгууллагыг хангах, Аюул ослын талаарх мэдээллийг шаардлагатай тохиолдолд холбогдох нэгжүүдэд мэдээлэл өгөх бүдүүвчийн дагуу мэдээлэх	Цацрагийн хяналтын улсын алба, Мэргэжлийн ангиуд Туслах ангиуд	Мэдээллийг цаг алдалгүй авах, өгөх холбооны хэрэгсэл, цацрагийн хэмжилтийн багаж төхөөрөмжүүд, хувийн дозиметр, хамгаалалтын хэрэгсэл, автомашин, Цацрагийн үүсгүүрийн улсын нэгдсэн бүртгэл, хяналт шалгалтын мэдээлэл, бусад лавлах материал
2	Ч+1,5-2,5 цагийн дараа	Цацрагийн осол, хордлого гарсан газар, байрлал, хугацаа, цаг агаарын нөхцөл байдлыг тогтоох, Болзошгүй аюул, ослын байдлыг судалж, шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. Шаардлагатай тохиолдолд цацрагийн аюул осол гарсан газарт холбогдох байгууллагуудаас оролцсон мэргэжлийн ажлын хэсгийг яаралтай томилж ажиллуулах асуудлыг улсын албанд тавьж шийдвэрлүүлэх	Цацрагийн хяналтын улсын алба, Мэргэжлийн ангиуд, Туслах ангиуд	Цацрагийн хэмжилтийн багаж төхөөрөмжүүд, хувийн дозиметр, хамгаалалтын хэрэгсэл, автомашин, шатахуун, бусад зардал
3	Ч+2,5-3,0 цагийн дараа	Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн заавар, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллагуудад шуурхай хүргүүлэх, Ослын голомтод ажиллаж буй хүмүүст дозиметрийн хяналт хийх, хувийн шарлагын тунг үнэлэх, Ослын голомтод ажиллах хүмүүст Кали-Иод зэрэг бэлдмэлийг уулгаж, дотоод шарлагаас сэргийлэх, Цацрагийн осол, хордлого болсон газрын орчинд тандалт хэмжилт хийх, аюулгүйн бүсийг тогтоон байрлуулах, цацрагийн бохирдол, цацрагийн тунгийн чадлын хэмжилт хийх, дүгнэлт гаргах	Цацрагийн хяналтын улсын алба, Мэргэжлийн ангиуд, Туслах ангиуд	Цацрагийн хэмжилтийн багаж төхөөрөмжүүд, хувийн дозиметр, хувийн хамгаалалтын хэрэгсэл, Кали-иод автомашин, шатахуун, бусад зардал
4	Ч+3,0-4,5 цагийн дараа	Мэргэжлийн заавар, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллагуудад шуурхай хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд ОУАЭА-аас мэргэжлийн тусламж, заавар хүсэх талаар улсын албанд хандах, Монгол орны гадаад орчны цацрагийн хяналтын цэгүүдийн, бэлэн байдлыг хангуулах, хэмжилтийн давтамжийг ойртуулж хяналт хийх, мэдээллийг шуурхай дамжуулах, Ослын газраас ирсэн тээврийн	Цацрагийн хяналтын улсын алба, Мэргэжлийн ангиуд, Туслах ангиуд	Цацрагийн хэмжилтийн багаж төхөөрөмжүүд, хувийн дозиметр, хамгаалалтын хэрэгсэл, авто машин, шатахуун, бусад зардал

		хэрэгсэл, зорчигчид, ачаа тээшинд цацрагийн бохирдлын хэмжилт хийх, дүнг холбогдох байгууллагуудад мэдээлэх, Цацраг идэвхт үүсгүүрийн ослын үед цацрагийн үүсгүүрийн блок, түүний хаяг шошгын зургийг авч баримтжуулах, боломжтой бол цацрагийн үүсгүүрийн зургийг авах, Цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх үед цацрагийн тунгийн чадлын хэмжилт хийж, тээвэрлэлтийн индексийг тогтоох, Цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч болон үүсгүүрийг харгалзан яваа хүний суудал дээр цацрагийн тунгийн чадлын хэмжилт хийх, тунг үнэлэх		
5	4+4,5-8,0 цагийн дараа	Шаардлагатай тохиолдолд хөрс, ус, хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлсээс дээж авч лабораторид шинжлэх, дүгнэлт гаргах, Цацрагийн ослын талаар дүгнэлт гаргаж, цацрагийн бохирдлыг арилгах, цацрагийн үүсгүүрийг аюулгүй болгох, хамгаалалт, хадгалалтанд авах арга хэмжээ авах, Болзошгүй цацрагийн аюул, ослын талаарх мэдээ мэдээллийг холбогдох газрууд, олон нийтэд мэдээлэх	Цацрагийн хяналтын улсын алба, Мэргэжлийн ангиуд, Туслах ангиуд	Цацрагийн хэмжилтийн багаж төхөөрөмжүүд, хувийн дози метр, хамгаалалтын хэрэгсэл, авто машин, шатахуун, бусад зардал

Бүлгүүдийн нийтлэг үүрэг

- Үүссэн нөхцөл байдлыг үнэлэх;
- Аюулгүй болгох, тогтвортой үйл ажиллагаагаар хангах;
- Урьдчилан сэргийлэх болон зайлшгүй эмнэлгийн тусламж авах талаарх, зөвлөмж, мэдээллээр хангах

Бүлэг тус бүрийн үүрэг:

АТБ: Агаарын тандалтын бүлэг

- Агаарын тандалтаар эзэнгүй болон хаягдсан үүсгүүрийн байршлыг тодорхойлж, хурдан хугацаанд илрүүлэх;
- Цацраг идэвхт изотоп тодорхойлох хэмжилтээр том хэмжээний газар нутгийн бохирдолыг тодорхойлох;
- Хэмжилтийн үр дүн, мэдээллээр тухай бүр нь холбогдох хэсгүүдийг хангах;

ЦХБ: Цацрагийн хяналтын бүлэг

- Хөрсний тандалтаар тухай газрын бохирдлын хил хязгаар, байршлыг тодорхойлох;
- Онцгой нөхцөл байдал үүссэн үед хамгаалалтын арга хэмжээнүүдийн талаарх саналыг дэвшүүлэх;
- Багаж хэрэгсэл, объект, хувь хүний бохирдлыг хянах;
- Тунгийн чадлыг хянах;
- Дээж авах хэсгийг тодорхойлох

ИТБ: Изотопыг тодорхойлох бүлэг

- Цацраг идэвхт изотопын хувийн идэвхийг тодорхойлох;
- Хөрсний хувийн бохирдлыг тодорхойлох;
- Дээж авах, бэлтгэх;
- Дээжин дэх цацраг идэвхт изотопын идэвхийг тодорхойлох (хөрс, ус, агаар, хүнсний бүтээгдэхүүн г.м)

ҮАББ: Үүсгүүрийг аюулгүй болгох бүлэг

- Үүсгүүрийг аюулгүй болгох ажлуудыг зохион байгуулах;
- Тусгай зориулалтын төхөөрөмжийн тусламжтайгаар үүсгүүрийг аюулгүй болгох;
- Үүсгүүрийн бүрэн бүтэн аюулгүй байдал, хадгалалт, албан хаагчдыг хамгаалах;
- Хэрэв шаардлагатай бол үүсгүүрийн тээвэрлэлт, хадгалалтын талаар зөвлөмж өгөх

ҮДШБ: Үнэлгээ, дүн шинжилгээний бүлэг

- Бүлгүүдийн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, мэдээллийг төвлөрүүлж, үнэлгээ хийх, баталгаажуулах;
- Цацрагт өртөмтгий бүлгийн эрхтэн болон хувийн тунг үнэлэх;
- Үр дагаврыг тооцоолох, үнэлэх, загварчилах;
- Хаягдлын менежмент, ариутгал халдваргүйжүүлэлт, цацрагийн хамгаалалт аюулгүй болгох стратегийг боловсруулах

ЭТҮБ: Эмнэлгийн тусламж үзүүлэх бүлэг

- Цацрагийн ослын үед шарлагаас урьдчилан сэргийлэх аргуудыг тооцоолох;
- Тухайн цацрагийн ослын нөхцөл байдалд тохирсон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, эмнэлгийн тусламж үйлчилгээнд тусгах тусгай зөвлөгөөг өгөх, (i) Дотоод шарлагын үед цацрагийн болон клиник хамж шинж хүчтэй илрэхэд хамгаалах, саармагжуулах арга хэмжээг авах, (ii) гадаад бохирдол, (iii) дотоод бохирдол, (iv) тухайн бүс нутагт илрэх цацрагийн хам шинж, болон (v) шарлагад өртсөн хүмүүсийг тусгаарлах гэх мэт.

БТБ: Биологийн туршилтын бүлэг

- Бодит нөхцөлд био туршилтын арга техникүүдийг ашиглаж хувийн тунгийн түвшнийг тодорхойлох /Тухай нэг эрхтэн болон бүтэн биеийн тоолуур, шарагдсан хэсгийг гаднаас нь тоолох/;
- Биологийн материал /ялгадас, хамрын ялгадас, үс, цус/ ашиглан хувийн тунгийн түвшнийг тодорхойлох

ЦЭСБ: Цацрагийн эмгэг судлалын бүлэг

- Задлан шинжилгээ болон тохиромжтой эд эсээс биопсын шинжилгээнд дээж авах;
- Эмгэг эд эс судлалын шинжилгээнд дээж бэлтгэх;
- Дээжийг үнэлэх;
-

БДБ: Биодозиметрийн бүлэг

- Дээжийг хүлээн авах;
- Дээж бэлтгэх;
- Дүгнэх, шинжилгээг удирдан зохион байгуулах

Туслах бүлгүүд

ДБ: Дээжлэлтийн бүлэг

- Агаараас дээж авах;
- Бохирдсон хөрс, хүнс, үр тариа, ус, гэх мэтээс дээж авах;
- Гамма цацрагийн тунгийн чадлыг хэмжих

АХБ: Ариутгал халдваргүйтгэлийн бүлэг

- Хувь хүн болон багаж төхөөрөмж бохирдохоос урьдчилан сэргийлэх;
- Хувь хүн болон багаж төхөөрөмжийн бохирдлыг хянах

ХБ: Хэмжилтийн бүлэг

- Байгууламжийн доторх цацрагийн тунгийн чадлыг хэмжих;
- Байгууламжийн доторх бохирдлын зэргийг тодорхойлох
-

ЛБ: Лабораторийн бүлэг

- Дээжийг хүлээн авах, бэлтгэх;
- Дээжинд изотопын анализ хийх;
- Дээжинд изотопын хувийн идэвхийг тодорхойлох

5.1.2.3.4. Хилийн нэвтрэх цэг дээр хэрэгжүүлэх хариу арга хэмжээ

Цацрагийн хяналтын төхөөрөмжид дохиолол, мэдээллийг хүлээн авах;

Дохиолол мэдээллийг баталгаажуулж, үнэлгээ хийх;

Биет үзлэг /хоёрдогч/ үзлэг шалгалт хийж, зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээллийг шалгах;

Цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн нэр, төрлийг тодорхойлж, хэмжилтийг дүн, авсан арга хэмжээний товч мэдээллийг “Мэдээлэл дамжуулах схем 2”-ын дагуу МХЕГ, холбогдох байгууллагад өгнө. Үүнд:

- Цацрагийн дохиолол, мэдээлэл илэрсэн байршил
- Хугацаа, он, сар, өдөр, цаг, мин
- Цацрагийн үүсгүүр эвсэл бохирдол илэрсэн объектийн тухай ерөнхий мэдээлэл
- Цацрагийн тунгийн чадал, цацрагийн түвшин /...мк³в/ц/
- Авсан арга хэмжээ

Схем 3-ын дагуу цацрагийн мэдээлэлд үнэлгээ хийж, ажиллах;

Хэмжилтийн протокол хөтөлж, зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа тээш түр саатуулах арга хэмжээ холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;


Илэрсэн зөвшөөрөлгүй цөмийн материал, цацрагийн үүсгүүр, багаж хэрэгсэл, рентген тоног төхөөрөмжийг түр тусгаарлаж, аюулгүйн бүс, ажиглалтын бүсийг тогтоож аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээг хил, хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах;

Хэмжилтийн спектр, фото зураг, мэдээ, мэдээллийг бэлтгэж шаардлагатай бүх байгууллагуудад хүргүүлэх;


Хилийн нэвтрэх цэг, гүний хяналтын бүсийн үйл ажиллагааг хэвийн горимд оруулахад бусад шаардлагатай бүх арга хэмжээ авч ажиллах;

ТУТ-ны менежер, зохицуулагчтай эрсдэлийн харилцаа холбоотой ажиллаж, хариу арга хэмжээний тайланг тогтоосон хугацаанд хүргүүлэх.

МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ СХЕМ



ЦАЦРАГИЙН МЭДЭЭЛЭЛД ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БҮДҮҮВЧ



5.1.2.4. Эрсдэлийн мэдээлэл харилцааны багийн үүрэг

Эрсдэлийн түвшин **"бага"** үед тайван цагийн горимоор ажиллаж дараах арга хэмжээг авна.Үүнд:

1. Үүсч болох эрсдэлээс сэргийлэх мэдлэг, мэдээлэл түгээнэ.
2. Орон нутгийн онцлогийг (газар зүй, уур амьсгал, байгалийн голомт гэх мэт) харгалзан, болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, тухайн хүн амын соёл, зан заншил, нийгэм,соёлын судалгаа хийж, мэдээллийн сувгуудыг туршин, бэлэн байдлыг хангасан байна.
3. Төр, хувийн хэвшлийн болон иргэний нийгэм, шашин, сайн дурынхан, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг хангана.
4. Зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл боловсруулж, түгээх, иргэдийн санаа бодлыг сонсох зэргээр эргэх холбоо тогтоож, хамтран ажиллана.
5. Иргэдийн дунд тархаж буй мэдээлэл, ам дамжсан цуу яриаг тандаж, залруулан, нотолгоонд суурилсан, үнэн зөв мэдээллийг түгээнэ.
6. Багийн гишүүд болон салбар хоорондын байгууллагын холбогдох ажилтныг хэвлэл мэдээллийн сувгаар олон нийттэй харилцах, олон нийтийг дайчлах, иргэдтэй нүүр тулж ажиллах зэрэг эрсдэлийн мэдээлэл харилцааны арга барилд сургах, чадавхжуулна.
7. Хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх албан тушаалтны нэрсийг гаргана.
8. Эрсдэлийн мэдээлэл харилцааны баг нь салбар хоорондын шуурхай мэдээллийн долоо хоног тутмын хэвлэлээр дамжуулан харилцан мэдээлэл солилцоно.

Эрсдэлийн түвшин **"дунд"** үед идэвхжлийн горимоор ажиллаж дараах арга хэмжээг авна.

1. Үйл явдлын мэдээллийг авмагц 2 цагийн дотор олон нийтэд мэдээлнэ.
2. Бодит байдлыг тухай бүр мэдээлж, олон нийтийг идэвхжүүлж, аюул осолд өртөхөөс сэрэмжлүүлж, өөрийгөө болон бусдыг эрсдэлээс хамгаалах шийдвэр гаргахад тус болох мэдээллээр хангана.
3. Олон нийтийг сонсож, учир шалтгааныг тайлбарлан таниулах, эрсдэлд өртсөн иргэдэд санаа зовниж байгаа асуудлаар үнэн бодит мэдээллийг ил тод хүргэнэ.
4. Багийн гишүүд тандалтын мэдээ, түүний баталгаажуулалт, эрсдэлийн үнэлгээ хийх явцад оролцож, бусад салбарын эрсдэлийн мэдээлэл харилцааны багийн гишүүдэд мэдээлэл түгээнэ.
5. Олон нийтэд хүргэх мэдээллийг эрсдэлийн үнэлгээнд суурилан боловсруулж, холбогдох албан тушаалтнаар хянуулан баталгаажуулж, түгээхэд бэлтгэнэ. Энэ үед хянаж баталгаажуулсан албан мэдээллийг хамтрагч байгууллагууд өөрчлөхгүй байхад онцгой анхаарна.
6. Зорилтот бүлгүүд, тэдний мэдээлэл, мэдлэгийн түвшинг тогтоож мэдээллийн стратеги, төлөвлөгөөг гаргана.
7. Шинэчлэгдсэн мэдээллийг хэрхэн яаж боловсруулж, түгээх талаар эрсдэлд орсон хүн амд шууд хүргэх оновчтой хувилбарыг сонгоно.
8. Томилогдсон албан тушаалтан, мэргэжилтнээр олон нийтэд хандаж мэдээлэл өгүүлнэ.
9. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, мониторинг хийж, цаашдын стратегийг боловсруулна.

Эрсдэлийн түвшин **"өндөр"** үед идэвхжлийн горимоор ажиллаж дараах арга хэмжээг авна.

1. Цацрагийн осол, хордлогын мэдээллийг авмагц 2 цагийн дотор олон нийтэд мэдээлнэ.

2. Эрсдэлийн мэдээлэл харилцааны салбар хоорондын баг нь эрсдэлийн түвшин нэмэгдэх үед дайчлах хүний нөөцтэй байх бөгөөд шинэчилсэн төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу хамтран ажиллана.

3. "Аюул, айдас аль аль нь их байна гэдгийг тайлбарлаж, хамтдаа даван туулахад боломж бүрийг ашиглах" зарчмыг баримтална.

4. Ерөнхий зохицуулагчийн шийдвэрээр эрсдэлийн мэдээлэл харилцааны салбар хоорондын багийг нэгжийн түвшинд хүч нэмэгдүүлэн томилон ажиллуулна.

5. Томилогдсон албан тушаалтан, мэргэжилтнээр олон нийтэд хандаж мэдээлэл өгүүлнэ.

Эрсдэлийн түвшин **"маш өндөр"** үед идэвхжлийн горимоор ажиллаж дараах арга хэмжээг авна.

1. Цацрагийн осол, хордлогын мэдээллийг авмагц 2 цагийн дотор олон нийтэд мэдээлнэ.

2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй бүхий л мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнг багийн бүх гишүүдэд өдөр тутам илгээнэ. Иргэдийн дундах аман ярианд тогтмол мониторинг хийнэ.

3. Мэдээлэл дамжуулах явцад холбогдох байгууллагуудын мэдээллийн агуулга зөрүүгүй байна.

4. Дотоод, гадаадын холбогдох байгууллагуудад үйл явдлын мэдээллийг тогтмол бэлтгэн хүргүүлнэ.

5. Аюулд өртсөн иргэдийн тухай тогтмол мэдээлнэ.

6. Эрсдэлийн түвшингээс хамааран олон нийтэд дараах албан тушаалтнууд олон нийтэд мэдээлэл өгнө.

6.1. Эрсдэлийн түвшин "маш өндөр" үед мэдээллийг Ерөнхий сайд эсвэл Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга;

6.2. Эрсдэлийн түвшин "өндөр" үед МХЕГ-ын дарга;

6.3. Эрсдэлийн түвшин "дунд" үед ТУТ-ны менежер, хариу арга хэмжээний багийн ахлагч;

6.4. Эрсдэлийн түвшин "бага" үед Эрсдэлийн мэдээлэл харилцааны багийн ахлагч, гишүүд, орон нутгийн удирдлага, төрийн байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус мэдээллийг хүргэнэ.

5.1.2.5. Санхүү, нөөцийн багийн үүрэг

1. Зардлын тооцоог гарган, бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэх;

2. Нөөцийн хуваарилалтыг оновчтой хийх;

3. Шаардлагатай үед барилга байгууламж, хоргодох далдлах байр, хэрэгцээт материалаар хангах, бэлэн байдлыг хангах, эм урвалж, хүнс, усны нөөцийг бий болгох ажлыг зохион байгуулах, нөхөн хангах арга хэмжээ авах;

4. Орон нутгийн болон олон улсын байгууллагын оролцоог хангах.

5. Цацрагийн осол, хордлогын үед нөөцийг бүрдүүлэх

6. Цацрагийн хяналтын улсын алба нь мэргэжлийн ангиудыг цацрагийн осол, хордлогоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үед шуурхай ажиллах, ослын үр дагаврыг арилгахад шаардагдах автомашин, техник хэрэгсэл, түшиц лаборатори, туслах материал, хэрэглэгдэх багаж төхөөрөмж, хүчдэлийн тэжээлийн бэлэн байдал, нөөцөөр хангаж, үүрэг гүйцэтгэх нөхцөлийг энэхүү зааврын 1 дүгээр зүйлд тусгасан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран бүрдүүлсэн байх;

7. Нийслэл, аймаг, дүүргийн хэмжээнд ашиглаж байгаа цацрагийн хэмжилтийн багаж хэрэгсэл, дозиметрийг шаардлагатай үед дайчлан ашиглах, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах, тухайн байгууллагуудын цацрагийн хэмжилтийн багаж хэрэгсэл, дозиметрийг шуурхай баталгаажуулах арга хэмжээг авах;

8. Мэргэжлийн ангийн ажил үүрэг гүйцэтгэх чадварыг цаг тухайд нь нөхөн сэргээж, хэвийн байдалд байлгах талаар холбогдох байгууллага, улсын албатай хамтарч ажиллана.

ЗУРГАА. ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Цацрагийн осол, хордлогын үед улсын байцаагчид хяналт шалгалтын явцад авсан сорьцыг ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын лабораторид шинжилгээг хийлгүүлнэ.

6.2. Эрсдэлийн түвшингээс хамааран “бага” эрсдэлтэй үед ажлын цагаар, дундаас дээш эрсдэлтэй үед лаборатори 24 цагийн тасралтгүй ажиллагааны горимд шилжин ажиллана.

6.3. Лаборатори нь шинжилгээний дүн мэдээг мэдээллийн нэгдсэн санд тухай бүр оруулна.

6.4. Лаборатори нь шинжилгээг стандарт арга, аргачлалын дагуу гүйцэтгэж, урьдчилсан дүнг гарсан даруйд холбогдох чиглэлийн улсын байцаагчид мэдэгдэж, эцсийн дүнг гармагц хүргүүлнэ.

6.5. Монгол Улсын хэмжээнд тухайн сорилтыг гүйцэтгэх боломжгүй, маргаан таслах шинжилгээний дүнг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд олон улс, бүс нутгийн итгэмжлэгдсэн лабораторит дээжийг хүргүүлж, шинжлүүлнэ.

---ooOoo---

БОЛЗОШГҮЙ ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ЗААВАР

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү зааврын зорилго нь цацрагийн осол, хордлогоос бусад болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед /хүний халдварт өвчний дэгдэлт, зоонозын шалтгаант халдварт өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, химийн осол, хордлого, байгалийн аюулт үзэгдэл, гамшиг/ мэргэжлийн хяналтын байгууллага болон салбар хоорондын байгууллагууд мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад оршино.

1.2. Энэхүү зааврыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын алба, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн улсын /ахлах/ байцаагч, ажилтан тус тус мөрдөж ажиллана.

1.3. Мэргэжлийн хяналтын байгууллага нь энэхүү зааврын 1.1-д заасан үйл явдлын үед хамтрах чиг үүрэгтэйгээр салбар хоорондын байгууллагуудтай ажиллана.

1.4. Зааврыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтална.

ХОЁР. НЭР ТОМЪЁО

2.1. “Үйл явдал” гэж нийгмийн эрүүл мэндэд ноцтой нөлөө үзүүлэх өвчний шинж тэмдэг, илрэл, өвчин гарах эрсдэлт хүчин зүйлийг;

2.2. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” гэж хүн ам, байгууллага, хамт олон, гэр бүлийн дунд гарсан шалтгаан нь тодорхойгүй нас баралтын 2 ба түүнээс дээш, шалтгаан нь тодорхойгүй өвчний 3 ба түүнээс дээш тохиолдол, хими, цацраг идэвхт бодис болон ус, хөрс, агаар, орчны бохирдлын нөлөөнд өртөх, мал амьтны өвчлөл, хорогдлын хэвийн бус байдал, шинэ, ховор үйл явдлыг;

2.3. “Тохиолдлын удирдлагын тогтолцоо” /ТУТ/ гэж гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээг эрсдэлийн төрөл, түвшинтэй уялдуулан нэгдсэн зохион байгуулалттайгаар удирдах, мэдээлэх, зохицуулах, хянах, цогц үйл ажиллагааг;

2.4. Идэвхжлийн зэрэг гэж үйл явдал, болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний тогтоосон хэм хэмжээг хэлнэ.

ГУРАВ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

3.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын анхны мэдээг хүлээн авсан улсын /ахлах/ байцаагч, ажилтан 10 минутын дотор “Схем 1”-ийн дагуу мэдээг дамжуулна.

3.1.1. Мэдээг хүлээн авсан нэгжийн удирдлага мэдээний төрлөөс шалтгаалан хариуцсан чиглэлийн улсын /ахлах/ байцаагчид нягталж баталгаажуулах үүргийг 10 минутын дотор өгнө.

3.1.2. Мэдээг баталгаажуулахдаа хүн ам олноор цугласан нийтийн арга хэмжээний үеэр гарсан, нас барсан тохиолдлууд адил шинж тэмдэгтэй,

бохирлогдсон ус, хүнстэй холбоотой байж болзошгүй, химийн бодис, цацраг идэвхит бодис алдагдсан, мал амьтан хорогдсон эсэх зэрэг шалгууруудыг тодруулна.

3.1.3. Дээрх шалгуурын нэгээс дээш асуултад “тийм” эсвэл “мэдэхгүй”, “тодорхойгүй” гэсэн тохиолдолд үйл явдал гэж үзэн баталгаажуулсаны даруйд нэгжийн удирдлагад эргэж мэдэгдэж, Шадар сайд, байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн “Үйл явдлын мэдээг бүртгэж, мэдээлэх хуудас” хүснэгт 1-ийн дагуу үйл явдлыг салбар хоорондын цахим мэдээллийн сан /цаашид EBS (Event based surveillance-үйл явдалд суурилсан тандалт) програм гэх/-д 2 цагийн дотор бүртгэж, оруулна.

3.2. Үйл явдлын талаарх анхны мэдээллийг EBS програмаас хүлээн авсан шуурхай мэдээлэл хариуцсан ажилтан “Схем 2”-ын дагуу мэдээ, мэдээллийг дамжуулна.

3.2.1. Шуурхай мэдээлэл хариуцсан ажилтан “EBS” програмд шинээр бүртгэгдэж байгаа мэдээллийг тухай бүрт нь мэдээлж ажиллана.

3.2.2. Мэдээлэл хүлээн авсан ажилтан мэдээллийн нууцлалыг хадгалж ажиллана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

4.1. Мэргэжлийн хяналтын байгууллага тэргүүлж ажиллах цацрагийн осол, хордлогын үед эрсдэлийн үнэлгээг нэгдүгээр хавсралтын 5 дугаар заалтад заасны дагуу хийнэ

4.2. Мэргэжлийн хяналтын байгууллага хамтарч ажиллах бусад үйл явдлын үед EBS програмаас “**дохио**” дамжуулмагц үйл явдлын төрлөөс хамаарч ТУТ-ны төвийн бүрэлдэхүүний Хариу арга хэмжээний багийн ахлагч, нэгжийн бүрэлдэхүүний зохицуулагчид салбар хоорондын багт орж ажиллан, эрсдэлийн үнэлгээ хийх чиглэлийг өгнө.

4.2.1. Эрсдэлийн үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнд орсон улсын /ахлах/ байцаагч Шадар сайд, байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу эрсдэлийн түргэвчилсэн болон явцын үнэлгээг салбар хоорондын байгууллагуудтай хамтран хийнэ.

4.2.2. Улсын /ахлах/ байцаагч эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардлагатай, хяналт шалгалтын мэдээллээр багийн ахлагч, гишүүдийг хангаж ажиллана.

4.2.3. Хамтарсан багаас эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний дүнг цахим мэдээллийн санд оруулмагц, багт орж ажилласан улсын /ахлах/ байцаагч өөрийн байгууллага, дээд шатны удирдлагыг тухайн мэдээллээр хангаж ажиллана.


4.2.4. Эрсдэлийн түвшингээс хамааран дараах байдлаар үйл ажиллагааг зохион байгуулна.

4.2.4.1. Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээгээр “бага” гэж үнэлэгдэж, явцын үнэлгээгээр 14 хоногийн хугацаанд эрсдэлийн түвшин нэмэгдээгүй бол нэгжийн түвшний бүрэлдэхүүн ажиллаж, энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад заасан зааврын дагуу хийсэн ажлын тайланг тэргүүлэх байгууллагад хүргүүлж, нэгдсэн тайланд тусгуулна. Түүнчлэн төвийн түвшний багт мэдээллийг тухай бүр хүргүүлж, мэргэжил арга зүйгээр хангагдаж ажиллана.


4.2.4.2. Эрсдэлийн түвшин “дунд”, “өндөр” үед эрсдэлийн явцын үнэлгээ хийхэд шаардлагатай бол бусад чиглэлийн хяналтын улсын байцаагч, ажилтныг татан оролцуулна. Үйл явдлыг тэргүүлэх байгууллагын шийдвэрээр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд төвийн түвшний холбогдох ТУТ-ны бүрэлдэхүүнээс нэмэлтээр орж, хамтран ажиллана.

4.2.4.3. Эрсдэлийн түвшин “маш өндөр” үед явцын үнэлгээ хийх үндэсний түвшний өргөтгөсөн багт үйл явдлын төрлөөс хамаарч ТУТ-ны төвийн бүрэлдэхүүнээс томилогдон ажиллана.

**БОЛЗОШГҮЙ ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ
БАЙДЛЫН ҮЕД МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН
ТҮВШИНД МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ СХЕМ**



БОЛЗОШГҮЙ ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ
БАЙДЛЫН ҮЕД МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН
ТҮВШИНД МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ СХЕМ



ТАВ. ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Хариу арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт

1. Үйл явдал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээг “Тохиолдлын удирдлагын тогтолцоо” /ТУТ/-ны бүрэлдэхүүнээр хэрэгжүүлнэ.

2. ТУТ-ны бүрэлдэхүүн нь бүдүүвч 1-10-д заасан зохицуулагч, менежер, хариу арга хэмжээний баг, эрсдэлийн мэдээлэл харилцааны баг, санхүү, нөөцийн багаас бүрдэнэ. Баг нь багийн ахлагч, гишүүдтэй байх ба ахлагч нь төвийн түвшинд тухайн чиглэлийн хэлтсийн дарга, нэгжийн түвшинд чиглэлийн хэлтсийн ахлах болон асуудал хариуцсан улсын /ахлах/ байцаагч байна.

3. Хяналтын газрууд хүснэгт 1-д заасны дагуу үйл явдлын төрлөөс хамааран тэргүүлэх болон хамтрах чиглэлээр хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Шаардлагатай тохиолдолд бусад хяналтын газруудыг татан оролцуулж болно.

Хүснэгт 1

№	Үйл явдлын төрөл	Тэргүүлэх хяналтын газар	Хамтрах хяналтын газар
1	Хүний халдварт өвчний дэгдэлт	ЭМБСХГ	ЭИХХЦХГ
2	Зоонозын шалтгаант халдварт өвчин	ЭМБСХГ	ХАБХААХГ, ЭИХХЦХГ
3	Мал, амьтны гоц халдварт өвчин	ХАБХААХГ	ЭИХХЦХГ, БОГУУХГ
4	Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт	ЭМБСХГ, ХНХХГ	ХАБХААХГ, ЭИХХЦХГ
5	Химийн осол, хордлого	БОГУУХГ	ЭМБСХГ, ХНХХГ, ЭИХХЦХГ
6	Цацрагийн осол, хордлого	ЦАБЦХГ	ДБХГ, ЭМБСХГ, ХНХХГ, ЭИХХЦХГ
7	Байгалийн аюулт үзэгдэл, гамшиг	ДБХГ	ЭМБСХГ, ХНХХГ, БОГУУХГ, ЭИХХЦХГ

5.2. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.2.1. Зохицуулагчийн үүрэг

5.2.1.1. Зохицуулагч нь төвийн түвшинд тухайн асуудал хариуцсан МХЕГ-ын дэд дарга, нэгжийн түвшинд НМХГ-ын тухайн асуудал хариуцсан дэд дарга, аймгийн МХГ, ХМХА-ны дарга байна.

5.2.1.2. Зохицуулагч нь хариу арга хэмжээний үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар ханган, багуудын үйл ажиллагааг чиглүүлэн уялдуулах;

5.2.1.3. Үүссэн нөхцөл байдалтай холбоотой үнэн зөв мэдээллээр байгууллагын удирдлагыг шуурхай хангаж ажиллах;

5.2.1.4. Багийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэх, багасгах шийдвэрийг гаргах;

5.2.1.5. Шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээний багийн гишүүдийг орон ажиллах ажилтны нөөцийн судалгааг гаргаж, бэлэн байдлыг хангах;

5.2.1.6. Хариу арга хэмжээний тайланг хянаж, баталгаажуулах.

5.2.2. Менежерийн үүрэг

5.2.2.1. Менежер нь төвийн түвшинд МХЕГ-ын холбогдох хяналтын газрын дарга, нэгжийн түвшинд аймаг, нийслэлийн МХГ-ын холбогдох хяналтын хэлтсийн дарга, ХМХА-ны хяналт шалгалтын хэлтсийн дарга байна.

5.2.2.2. Менежер нь багуудын үйл ажиллагааг тодорхойлон уялдуулах;

5.2.2.3. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтоож, хариу арга хэмжээг төлөвлөн, удирдах;

5.2.2.4. ТУТ-ны бүрэлдэхүүнийг хянаж, ажилтан эзгүй тохиолдолд орлон ажиллах хүнийг зохицуулагчтай зөвшилцөн томилох;

5.2.2.5. Багийн бүрэлдэхүүнд орж ажиллаж буй улсын байцаагч, ажилтны үүргийг тодорхойлох, удирдан чиглүүлэх, хяналт тавих;

5.2.2.6. Бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

5.2.2.7. Олон нийтэд мэдээлэх мэдээллийн тоймыг хянан баталгаажуулах, мэдээлэх;

5.2.2.8. Шуурхай хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох, хэрэгжилтэд хяналт тавих;

5.2.2.9. Салбар хоорондын байгууллагуудтай хамтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

5.2.2.10. Хариу арга хэмжээний тайланг хянаж, зохицуулагчид танилцуулах.

5.2.3. Хариу арга хэмжээний багийн үүрэг

5.2.3.1. Багийн ахлагчийн үүрэг

5.2.3.1.1. Хариу арга хэмжээний төлөвлөгөөг шуурхай боловсруулан, батлуулах, тодотгол хийх;

5.2.3.1.2. Үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээг төлөвлөх;

5.2.3.1.3. Хариу арга хэмжээг шуурхай авч, эрсдэлийн түргэвчилсэн болон явцын үнэлгээг хийж, менежер, зохицуулагчид танилцуулах;

5.2.3.1.4. Зохицуулагч, менежерийг үнэн зөв, бодитой мэдээллээр шуурхай хангаж, тулгамдсан асуудлыг тавьж шийдвэрлүүлэх;

5.2.3.1.5. Багийн гишүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

5.2.3.1.6. Үүссэн нөхцөл байдлын талаар үнэн зөв мэдээллийг бэлтгэн, эрсдэлийн мэдээлэл харилцааны баг болон менежер зохицуулагчид хүргэх;

5.2.3.1.7. Шаардлагатай нөөцийн жагсаалтыг санхүү, нөөцийн багт хүргүүлж, шийдвэрлүүлэх;

5.2.3.1.8. Эрсдэлийн мэдээлэл харилцааны багийн бүрэлдэхүүнд орж ажиллах;

5.2.3.1.9. Бусад багуудтай ажлын уялдааг хангаж ажиллах;

5.2.3.1.10. Хариу арга хэмжээний явцын болон гүйцэтгэлийн тайланг гаргаж, менежер, зохицуулагчид танилцуулах.

5.2.3.2. Багийн гишүүдийн нийтлэг үүрэг

5.2.3.2.1. Хариу арга хэмжээний төвийн болон нэгжийн бүрэлдэхүүнд энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан аргачлалд тусгасан удирдах албан тушаалтан, улсын /ахлах/ байцаагч, ажилтан ажиллана.

5.2.3.2.2. Багийн бүрэлдэхүүнд орсон улсын /ахлах/ байцаагч, ажилтан болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын дэгдэлт гарсан газарт үзлэг шалгалт, тандалт хийж, шалтгаан нөхцөлийг тогтоох, цаашид дамжин тархахаас сэргийлэх, таслан зогсоох шуурхай хариу арга хэмжээг авах;

5.2.3.2.3. Хариу арга хэмжээний төвийн түвшний бүрэлдэхүүний чиглэлийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нь менежер, зохицуулагч, нэгжийн түвшний бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүй болон баталгаатай мэдээллээр тогтмол хангаж, салбар дундын байгууллагатай ажлыг уялдуулж, хариу арга хэмжээний бодлогыг оновчтой, шуурхай тодорхойлж, ажиллах;

5.2.3.2.4. Үйл явдал бүртгэсэн газрын эрсдэлийн түвшин, өмнө хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн түүхийн талаарх мэдээллийг шаардлагатай тохиолдолд "Мэргэжлийн хяналтын шилэн хяналтын систем"-ийн мэдээллийн сангаас авч, хариу арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэхэд ашиглах;

5.2.3.2.5. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан зааварт тусгагдаагүй чиг үүрэгт хамааралтай бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

5.2.3.3. Багийн гишүүдийн мэргэжлийн чиг үүрэг

5.2.3.3.1 Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

А. Хүний халдварт өвчин, зоонозын шалтгаант халдварт өвчний үед:

1. Үйл явдлын анхны мэдээллийг салбар хоорондын байгууллагаас түрүүлж авсан бол мэдээллийг нягтлах, авсан мэдээллээ цахим мэдээллийн санд оруулах;
2. Багийн ахлагчийг үнэн зөв, бодитой мэдээллээр шуурхай хангаж ажиллах;
3. Орон нутгийн нөөцөд байгаа эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
4. Урьдчилан сэргийлэх, байнгын болон эцсийн халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
5. Халдваргүйтгэлийн бодисын үндсэн үйлчлэх бодисын идэвхи, халдваргүйжүүлэх үйлчилгээг лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргах;
6. Эмнэлгийн зарим тасаг, нэгжийг хаах, ор дэлгэх тохиолдолд халдвар хамгааллын дэглэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, бусад тасаг, нэгжийн үйлчлүүлэгчийг эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
7. Эх уурхай болон хавьтлыг тусгаарлан эмчлэх, сэргийлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж, зөвлөн туслах;
8. Халдварыг тархаахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, сэрэмжлүүлэг, сургалт, сурталчилгаа хийх;
9. Халдварын эрсдэлд өртөх хүн амын бүлгийг тодорхойлоход эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллах;
10. Үзвэр үйлчилгээ, нийтийн арга хэмжээг хязгаарлах арга хэмжээ авсан үед хэрэгжилтэд хяналт тавих;

Б. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед:

“Хоол хүнсээр дамжих өвчний (ХХДӨ) дэгдэлтийн үед авах хариу арга хэмжээг объектийн төрлөөс хамааран хүнсний худалдаа, нийтэд үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар, хүнсний үйлдвэр, зорчигчийн хоол, хүнс бэлтгэдэг газар, гэр бүлийн дунд хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын, хүүхдийн байгууллагад хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын, эрүүл мэндийн байгууллага (эмнэлэг, сувилал, асрамж, халамжийн газар)-д халдвар судлалын хяналтын асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын, амралт, жуулчны бааз, зочид буудалд орчны эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын, үйлдвэр, уурхай, зам, барилгын ажилчдын хоолны газарт хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын, хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагч ажиллана.

1. Тухайн дэгдэлтийн талаарх мэдээллийг (өртсөн хүний тоо, хэрэглэсэн хоол хүнс, хэрэглэсэн хугацаа, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдэг, илэрсэн хугацаа, өвчний явц, өвчтэй хүмүүстэй хамт байсан эсэх, хэрэглэсэн хоол хүнс, ижил төстэй шинж тэмдэг илэрсэн хүмүүс эргэн тойронд нь байсан эсэх зэрэг бусад хүчин зүйл) авах;
2. Дэгдэлт гарсан газрын удирдах ажилтан, албан тушаалтныг байлцуулан тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, онцлог, хүчин чадал зэргийг тодруулах;

3. Дэгдэлтийг үүсгэсэн байж болзошгүй сэжигтэй хоол, хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, савлах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүхий л үе шатыг тодруулах;

4. Дэгдэлтийг үүсгэсэн байж болзошгүй сэжиглэсэн хоол, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн байдлыг шалгах (нийлүүлсэн газрын нэр, хаяг, худалдан авсан он, сар өдөр, цаг, тоо хэмжээ, савласан хэлбэр, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа, цувралын дугаар, зэргийг түүхий эд, бүтээгдэхүүний шошго, дагалдах бичиг баримтыг үндэслэн тодруулах);

5. Ялангуяа хүүхдийн байгууллагад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хаанаас бэлтгэдэг, малчдаас шууд авдаг эсэх, шинжилгээ баталгаажилтад хамруулж нийлүүлдэг эсэхийг нягтлах;

6. Хүнсний бүтээгдэхүүний савлалт (лаазалсан, битүүмжилсэн, вакумдсан, битүүмжлэл алдагдсан, зориулалтын бус г.м), хуурамч бүтээгдэхүүн эсэхийг шалгах;

7. Түүхий эд, бүтээгдэхүүний орц найрлагын бүрэлдэхүүн хэсгүүдийн баталгаажилтыг шалгах;

8. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний зарцуулалтын байдлыг шалгах;

9. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй байр, өрөө тасалгааны байршил, технологи урсгал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах;

10. Шат дамжлага бүрт хэн ажилладаг болохыг тодруулж, урсгал бүдүүвчийн дагуу үе шат бүрт байж болох эрсдэлийг тодорхойлох;

11. Технологийн горимын мөрдөлт, боловсруулалтын үйл ажиллагаа нь өвчин үүсгэгчийг устгаж чадаж буй эсэхийг шалгаж, шаардлагатай тохиолдолд хоол, хүнсний бүтээгдэхүүний температурыг газар дээр нь хэмжих;

12. Үйл ажиллагааны явцад дамжин бохирдолт үүсэх нөхцөл байсан эсэхийг шалгах;

13. Түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, хадгалалт, тээвэрлэлт, түгээх үеийн температурын горимын мөрдөлтийг шалгах;

14. Идсэн болон үйлдвэрлэсэн хоол, хүнснээс дээж авсан эсэх, дээжийг зөв авч, зохих хэмд хадгалж, устгасан байдлыг шалгах;

15. Хувь хүн, ажиллагсдад тавигдах эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилт, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тушаал шийдвэрт заасны дагуу бүрэн хамрагдсан эсэхийг шалгах;

16. Дэгдэлттэй холбоотой байж болзошгүй химийн бодис болон бусад зүйлсийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, зайлуулалт устгалын байдлыг шалгах;

17. Сэжиглэсэн хоол, хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн хүнсний үйлдвэр, үйлчилгээний газрын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, технологийн урсгалын байдлыг шалгах;

18. Усан хангамж, гэрэлтүүлэг, агааржуулалт, хог хаягдал, бохир усны зайлуулалтын байдлыг шалгах;

19. Цэцэрлэг, сургууль, түүний дотуур байр, үдийн цайны хоол хүнсийг бэлтгэдэг гал тогооны усан хангамж тусдаа өөр өөр эх үүсвэртэй эсэх, тус бүрийг шинжилгээнд хамруулсан байдал, Үдийн цай хөтөлбөрт хамрагддаг хүүхдүүдийн гар угаах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх зэргийг нэг бүрчлэн шалгах;

20. Үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, сав суулгын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн горимын мөрдөлтийг шалгах;

21. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох бичиг баримтын бүрдэл (ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл, лабораторийн шинжилгээний дүн, татан авсан бүтээгдэхүүний бүртгэл, технологийн жор заавар, дотоод хяналт шалгалтын бүртгэл г.м), хүнсний аюулгүй байдлын талаар мөрдөж ажилладаг журам, заавар, дүрэмтэй эсэх, тэдгээрийн хэрэгжилтийн байдлыг шалгах;

22. Одоо байгаа болон өмнө нь илэрч байсан зөрчлүүд, түүний давтамж, зөрчлийг арилгах талаар авсан арга хэмжээг тодруулах;

23. Дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагаа болон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс сорьц, дээж авч лабораторийн шинжилгээнд тогтмол хамруулж буй байдалд хяналт тавих;

24. Шавж, мэрэгчгүйтгэлийг улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодисын баталгаажилт, батлагдсан зааврын дагуу зөв найруулж, хэрэглэдэг эсэхийг шалгах;

25. Хордлого үүсгэсэн байж болзошгүй сэжигтэй хоол, хүнсний бүтээгдэхүүн, түүний үлдэгдэл бусад зүйлсээс тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй аргачлалын дагуу лабораторийн шинжилгээнд дээж авч, тохиромжтой нөхцөлд хадгалж, 6 цагийн дотор энэхүү тушаалын гуравдугаар хавсралтад заасан тухайн бүтээгдэхүүн, үзүүлэлтээр итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээнд хамруулах ба дээд шатны эрх бүхий лавлагаа лабораториор баталгаажуулалт хийлгэнэ.

Дээжийг 6 цагийн дотор лабораторид хүргэх боломжгүй тохиолдолд лабораторид урьдчилан мэдэгдэж, хадгалалтын үеийн горимыг баримтлан 3 хоногоос хэтрүүлэхгүйгээр хүргэнэ. Шаардлагатай тохиолдолд эд зүйлс, багаж тоног төхөөрөмжөөс нян судлалын арчдас, ус, хөрснөөс дээж авч, холбогдох лабораторид хүргүүлнэ.

26. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлүүдийг баримтжуулж, шаардлагатай гэж үзвэл зураг авах, видео бичлэг хийх;

27. ХХДӨ-ний дэгдэлтийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж, менежерээр хянуулах, шаардлагатай тохиолдолд мэдээлэх;

28. Шаардлагатай тохиолдолд холбогдох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, материалыг шалтгааныг тогтоотол битүүмжлэх, хураан авах, түргэн гэмтэх бүтээгдэхүүнийг газар дээр нь устгах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

29. Лабораторийн шинжилгээний дүнгээр шаардлага хангахгүй гарсан бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авахуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

30. Хяналт шалгалтын явцад хүний амь нас, эрүүл мэндэд аюултай, гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг холбогдох журмын дагуу шийдвэрлэх;

31. Дэгдэлт гарах нөхцөлийг бүрдүүлсэн хүнсний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний болон тэдгээртэй адилтгах байгууллагуудыг шалгаж, сэжигтэй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, худалдаалах, хэрэглэхийг хориглох арга хэмжээ авах;

32. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн нь тогтоогдсон, зөрчил илэрсэн байгууллага, аж ахуйн нэгжид илэрсэн зөрчлийг арилгуулах, засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, технологи ажиллагаа, жор орцыг өөрчлөх, дотоодын хяналтын тогтолцоог сайжруулах, ажиллагсадыг тархвар судлалын заалтаар эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах, ариун цэврийн дэглэмийг чанд мөрдүүлэн сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

33. ХХДӨ-ний халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээ авч хөл хорио тогтоох, өвчлөгсдийг ажил, сургуулиас чөлөөлөх арга хэмжээг авахуулахаар холбогдох газруудад санал дүгнэлт хүргүүлэх;

34. ХХДӨ-ний дэгдэлт гарах шалтгаан нөхцөлийг бүрдүүлж, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан болон учруулахыг завдсан гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах;

35. Дэгдэлтийн талаарх хяналт шалгалтын дүнг нэгтгэн, аймгийн ЭМГ, нийслэлд ХӨСҮТ-ийн тархвар судлагч эмчтэй хамтран 3 хоногийн дотор урьдчилсан, 15 хоногийн дотор эцсийн дүгнэлтийг гаргаж, хамтарсан тайлан бичиж, цахим мэдээллийн санд оруулах ба дээд шатны байгууллагад албан бичгээр хүргүүлэх, архивлах;

36. Дэгдэлтийн эцсийн тайланд дэгдэлт гарсан газар, өртсөн, өвчилсөн, эмнэлэгт хэвтсэн, нас барсан хүний тоо, илэрсэн шинж тэмдэг, өвчилсөн огноо,

хордлого, халдвар үүсгэсэн хоол хүнсний нэр, түүнийг үйлдвэрлэсэн, бэлтгэсэн, худалдаж авсан газрын нэр, нөлөөлсөн хүчин зүйлс, шинжилгээ хийлгэсэн лабораторийн нэр, хоол хүнс, өвчтнөөс илэрсэн үүсгэгч болон хорт бодисын нэр, бататгах шинжилгээ хийлгэсэн бол лавлагаа шинжилгээг хийлгэсэн лабораторийн нэр, эцсийн онош, оношийн баталгаажилт, хордлого, халдварын эх уурхай, дамжсан зам, авсан хяналтын арга хэмжээ/үйл ажиллагаа зогсоосон, битүүмжилсэн, татан авахуулсан, устгасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, мөнгөн дүн, илрүүлсэн, арилгуулсан зөрчлийн агуулга, тоо/тухайн хоол, хүнсийг бэлтгэсэн газрын үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, дэгдэлтийг үүсгэсэн шалтгаан, дамжсан зам, нөлөөлсөн хүчин зүйлд дүн шинжилгээ хийн дүгнэлт гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг тусгасан байна.

В. Химийн осол хордлогын үед:

1. Химийн бодисын ослын үед алдагдсан бодисын нэр төрөл, хэмжээ, физик, химийн шинж чанар, эрүүл мэнд байгаль орчинд үзүүлж болох нөлөөллийн талаарх мэдээллийг судлах;

2. Химийн бодисын осол, хордлого гарсан бүс нутагт Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн онцгой байдлын газраас цагийн байдлыг үнэлж, халуун бүс, болзошгүй хордолтын бүсийг тогтоож, химийн бодисыг цэвэрлэж саармагжуулалт хийсний дараа орчны шинжилгээний дээжийг авах;

3. Орчны агаар, хөрсний дээж авах цэгийг халуун бүс, болзошгүй хордолтын бүсэд тогтоох ба дээж авах арга зүй, хугацаа, давтамж зэргийг холбогдох стандартад заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд, химийн бодис хариуцсан байгаль орчны хяналтын улсын байцаагчидтай хамтран тодорхойлох;

4. Орчны агаар, хөрснөөс авах дээжийн тоо хэмжээ нь химийн бодисоор бохирдсон орчныг төлөөлж чадахуйц хэмжээтэй байхад анхаарах;

5. Хөрсний шинжилгээний дээжийг 0-1 см, 25 см, 50 см, 1 м гүнээс тус бүр 1кг дээжийг урьдчилан бэлтгэсэн цэвэр саванд авч, хөрсний чийг, температурыг алдагдуулахааргүй хамгаалсан нөхцөлд тээвэрлэн хадгалж, 24 цагийн дотор лабораторид хүргэх;

6. Химийн бодисын осол, хордлого гарсан халуун бүс, болзошгүй хордолтын бүсэд ундны усны эх үүсвэрийн худаг, өргөлтийн болон дамжуулан шахах насос станц, ус түгээх байр, гол горхи, булаг шанд байгаа тохиолдолд усны дээж авч шинжилгээнд хамруулах;

7. Ундны усны дээжийг полиэтилен, полипропилен, поликарбонат болон шилэн саванд, органик химийн бодисыг тодорхойлох тохиолдолд зөвхөн шилэн саванд авна. Натри, кали, бор, цахиур тодорхойлох тохиолдолд зөвхөн полиэтилен саванд дээжийг авна.

8. Гол горхины уснаас дээж авахдаа усны гадаргуу, гүн хэсгээс тус тусад нь дээж авна.

9. Авсан дээжийг хаяглан, гэрэл, сэгсрэлтээс хамгаалагдсан нөхцөлд тээвэрлэн, 24 цагийн дотор лаборатоид хүргүүлэх;

10. Орчны агаарын дээжийг шинжилгээ хийх лабораторийн мэргэжилтэн, хөрс, усны дээжийг орчны эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч авна.

11. Орчны агаар, хөрсний дээжийг авахдаа харьцуулах зорилгоор химийн бодисын бохирдол үүсээгүй цэвэр орчноос 2-оос доошгүй дээжийг авна.

12. Гадаад, дотоод орчны агаар, хөрс, усны дээжинд хийсэн шинжилгээний дүнг холбогдох стандарт, суурь судалгаагаар тогтоосон хэмжээтэй харьцуулж үнэлгээ өгч, улсын байцаагчийн дүгнэлт гаргана. Хэрэв үндэсний стандартад тухайн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоогоогүй тохиолдолд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Европын холбоо, Канадын болон АНУ-ын байгаль орчны яам зэрэг байгууллагаас гаргасан зөвлөмж хэмжээтэй харьцуулж үнэлгээ өгч, дүгнэлт гаргана.

13. Орчны агаар, хөрс, уснаас авсан дээжинд МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори (ХАБҮЛЛ), Байгаль орчны шинжилгээний төв лаборатори болон тухайн шинжлэх үзүүлэлтээр итгэмжлэгдсэн бусад лабораториудад шинжилгээг хийлгэнэ. Шаардлагатай тохиолдолд 2-оос дээш лабораторид шинжилгээг зэрэгцээ хийлгэж болно.

14. Шинжилгээгээр тухайн химийн бодис стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их гарсан тохиолдолд дахин саармагжуулалт хийлгэж давтан дээж авч, шинжилгээ хийлгэн, улсын байцаагчийн дүгнэлт гаргана.

15. Химийн осол хордлого гарсан тухайн газар нутгийг байнгын хяналтанд 2 жил байлгаж, 6 сар тутам агаар, хөрс, усны шинжилгээг хийлгэж үнэлгээ дүгнэлт өгч ажиллана.

Г. Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед:

Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын болон хүнсний чанар, стандартын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

1. Байгалийн аюулт үзэгдэл, гамшигт өртсөн хүн амын хоол хүнсний хангамж, тээвэрлэлтийн нөхцөл, хадгалалтын байдалд дараах хяналтыг тавьж, мэргэжиларга зүйн зөвлөгөө өгч ажиллана. Үүнд:

2. Хүнсний хангамжийн байдал, бүтээгдэхүүний баталгаажилтын байдлыг хянах;

3. Улсын нөөцийн хүнсний бүтээгдэхүүнээс хангалт хийх тохиолдолд бүтээгдэхүүний хадгалалт, баталгаажилт, тээвэрлэлтийн нөхцөлд хяналт тавих;

4. Шаардлагатай тохиолдолд хүнсний хангалт хийх гэж буй түүхий эд, бүтээгдэхүүнээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулан, дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх;

5. Бүтээгдэхүүний тээвэрлэлт, түгээлтийн үед бүтээгдэхүүнийг хадгалах хэм хэрхэн зөрчигдөж болзошгүй эсэхийг хянах;

6. Гамшиг болсон газарт хүнсний бүтээгдэхүүнийг зөв хадгалж, хэрэглэх талаар зөвлөгөө өгөх;

7. Гамшигт өртөгсдийн зөөврийн болон бэлтгэн нийлүүлж буй хоол хүнсэнд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

8. Гамшигт өртсөн хүмүүсийн түр хорогдох байрны усан хангамж, аяга, таваг, гар угаах нөхцөлийг шалгаж, талаар мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх;

9. Зөөврөөр ундны усыг хангаж байгаа тохиолдолд ус зөөвөрлөх машин, ус хадгалах савны угаалга цэвэрлэгээг хэрхэн хийх талаар зөвлөгөө өгөх;

10. Байгалийн аюулт үзэгдэл, гамшигт өртсөн хүн амд боломжтой бол гараа угаах, хоол хүнсний зөв хэрэглээ, үүсч болох эрсдэлээс сэргийлэх зөвлөмжийг боловсруулж, зөвлөгөө мэдээлэл хийх, зөвлөмж, мэдээлэл тараах ажлыг зохион байгуулах;

11. Байгалийн аюулт үзэгдэл, гамшигт өртсөн хүн амын дунд хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт гарсан тохиолдолд энэхүү зааврын 5.2.3.3.1 дэх хэсгийн Б-д заасны дагуу шуурхай ажиллах;

12. Хяналтын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг байгууллагын болон холбогдох газарт цаг тухай бүрд нь мэдээлж, шуурхай ажиллах.

Халдвар судлалын асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

1. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийг тогтоох, захиалахад эрүүл мэндийн байгууллагатай хамтрах;

2. Орон нутгийн нөөцөд байгаа эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3. Эмнэлгийн зарим тасаг, нэгжийг хааж, ор дэлгэх тохиолдолд халдвар хамгааллын дэглэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, бусад тасаг, нэгжийн

үйлчлүүлэгчийг эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

4. Гамшигт өртөгсдөд үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж, зөвлөн туслах;

Орчны асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

1. Байгалийн аюулт үзэгдэл, гамшигт өртсөн нутаг дэвсгэрийн ундны ус хангамжийн эх үүсвэрийн худаг, өргөх болон дамжуулан шахах насос станц, ус түгээх байруудын усыг шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргах;

2. Ундны ус хангамжийн эх үүсвэр гамшигт өртсөн тохиолдолд холбогдох газрын мэргэжилтнүүдтэй хамтран ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд шинжилгээнд хамруулан үнэлгээ дүгнэлт өгөх;

3. Булаг шанд, гол горхи, хувиараа гаргасан худгийн усыг хүнсэнд хэрэглэхгүй байх, ундны усыг баталгаат эх үүсвэрээс авч буцалгаж хэрэглэх талаар иргэдэд чиглэсэн зөвлөмж гаргах;

4. Аюулт үзэгдэл, гамшигийн дараа хөрсний халдваргүйжүүлэлт хийхийн өмнө болон дараа хөрснөөс дээж авч, ХАБҮЛЛ болон аймаг нийслэлийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргах ба шинжилгээний дүнг үндэслэн зөвлөмж өгөх;

5. Төв суурин газрын хог хаягдлын нэгдсэн цэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

6. Хөрсний халдваргүйтгэл хийх бодисын үндсэн үйлчлэх бодисын идэвхи, халдваргүйжүүлэх үйлчилгээг лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргах.

5.2.3.3.2. Эмчилгээний чанарын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

Эрүүл мэндийн байгууллагуудад хүснэгт 2-д заасны дагуу хяналт шалгалт хийх;

1. Хордлого, халдварыг сэжиглэсэн, анх оношилсон эрүүл мэндийн ажилтан Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газарт яаралтай мэдээлсэн эсэхийг нягтлах;

2. Эм, химийн бодисын хордлого, хоол хүнснээс шалтгаалсан өвчний дэгдэлтийн үед сэжигтэй өвчтнөөс шаардлагатай шинжлэгдэхүүн /цус, бөөлжис, ходоодны угаадас, өтгөн, шээс, хамар, залгиур, шулуун гэдэсний арчдас/-ийг антибиотик эмчилгээ эхлэхээс өмнө холбогдох журам, стандартын дагуу авсан эсэх, авсан шинжлэгдэхүүнийг лабораторит хүргэх хүртэл хугацаанд зөв хадгалсан эсэх;

3. Гамшиг, осол, хордлогын дэгдэлтийн үед нэрвэгдсэн, сэжигтэй, өвчилсөн тохиолдлын тоо эмнэлгийн хүчин чадлаас давсан, нутаг орны олон байрлалд тохиолдлууд байгаа бол эмнэлгийн машин техник, тоног төхөөрөмж, эм хэрэгсэл, хүний нөөцийн хүрэлцээний байдалд үнэлгээ хийж, зохицуулалтын арга хэмжээ авах асуудлаар тухайн орон нутгийн Эрүүл мэндийн газарт тухай бүр мэдээлсэн эсэх;

4. Дэгдэлтийн үед эрэмблэн ангиллыг зөв хийж, тусламж үйлчилгээний шуурхай байдлыг хангаж, ажиллаж буй эсэх;

5. Үйлчлүүлэгчийн оношлогоо, эмчилгээний асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмч мэргэжилтэний зөвлөгөө тусалцаа авч ажилласан эсэх;

6. Осол гэмтэл, хордлого, халдварын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал бүрэн хангагдсан эсэх;

7. Үүссэн нөхцөл байдалд байгууллагын нөөцийн болон үйл ажиллагааны байдалд эрсдэлийн үнэлгээ хийж хариу арга хэмжээний алхам /яаралтай, шууд, уртасгасан арга хэмжээ/-уудыг хэрэгжүүлсэн эсэхийг тус тус шалгах.

№	Асуудал	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1.	Мэдээллийг авсан даруйдаа үйл явдал өрнөж буй эрүүл мэндийн байгууллага хот суурин газарт байрлаж байгаа бол биеэр хүрч очиж, алслагдсан байрлалд байгаа бол холбоо, мэдээллийн хэрэгслийг ашиглан хордлого, халдварыг сэжиглэсэн, анх оношилсон эрүүл мэндийн ажилтан Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн байгууллагад яаралтай мэдээлсэн эсэхийг нягтлах	1) Хэрэв ХХДӨ-ий сэжигтэй тохиолдол бол Журам, заавар батлах тухай ЭМС-ын 2017 оны 328 тоот тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Маягт 1-ийн дагуу ЭМГ-т мэдээлсэн байх 2) Химийн бодисын хордолтын тохиолдол дэгдэлт бол Химийн бодисын хордлогыг тандах мэдээлэх журам батлах тухай ЭМС-ын 2013 оны 467 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Маягт 1 болон 3 дугаар хавсралтын Б-д заагдсан мэдээллийн урсгалын дагуу ЭМГ, ОБГ, ЦГ-т мэдээлсэн байх
2.	Эм, химийн бодисын хордолт болон ялангуяа ХХДӨ-ий сэжигтэй, өвчилсөн тохиолдол байвал хүн бүрээс сүүлийн 72 цагийн дотор идэж ууж хэрэглэсэн хоол хүнс, ус, бусад бодис, бүтээгдэхүүний талаар асуумж авч, сэжигтэй хоол хүнс, бусад бодис, бүтээгдэхүүнийг хэрэглэж болохгүй талаар зөвлөмж өгч, битүүмжилсэн эсэхийг	1) Үйл явдлын талаарх асуумжийг маш тодорхой авсан байх 2) Хэрэв ХХДӨ-ий сэжигтэй тохиолдолд сүүлийн 72 цагт хэрэглэсэн хоол хүнс, ус, хоол хүнсний түүхий эд бүтээгдэхүүний талаар асуумжийг сайтар авсан байх, тухайлбал харагдах байдал, үнэр, амтны байдал ямар байсан, хэрэглэсэн хэмжээ, боловсруулсан арга зэргийг сайтар тодруулсан байх 3) Хэрвээ эм уусантай холбоотой асуудал байвал /хүүхэд, ахмад настан/ байнга хэрэглэдэг эм үү, эсвэл санамсаргүй байдлаар хэрэглэсэн байна уу, уусан гэх эмийн тоо, хэмжээ, хэлбэр нь ямар байсныг асууж тодруулсан байх 4) Химийн бодистой холбоотой асуудал байвал ямар савалгаатай байсан, хаяг шошго, тэмдэг тэмдэглэгээ байсан эсэх, хэрэглэсэн арга /үнэртэх, уух/, хэмжээний талаар асууж, тэмдэглэсэн байх
3.	Эм, химийн бодисын хордолт болон ялангуяа ХХДӨ-ийг сэжигтэй, өвчилсөн хүн бүрээс шаардлагатай шинжлэгдэхүүн /цус, бөөлжис, ходоодны угаадас, өтгөн, шээс, хамар, залгиур, шулуун гэдэсний арчдас/-ийг антибиотик эмчилгээ эхлэхээс өмнө хүрэлцэхүйц хэмжээтэйгээр авсан эсэх, авсан шинжлэгдэхүүнийг лабораторит хүргэх хүртэл хугацаанд хадгалах нөхцөл бүрдүүлсэн эсэхийг	1) Журам, заавар батлах тухай ЭМС-ын 2017 оны 328 тоот тушаалын 3 дугаар хавсралтын 4.4 дэх хэсэг (Шинжлэгдэхүүний төрөл) -ийн 4.4.1-4.4.10 –т заасан шинжилгээнүүдийг авч 4.4.11-т заасан горимын дагуу хадгалсан байх
4.	Гамшиг, осол, хордлогын үед нэрвэгдсэн, сэжигтэй, өвчилсөн тохиолдлын тоо эмнэлгийн хүчин чадлаас давсан, нутаг орны олон байрлалд тохиолдлууд байгаа бол эмнэлгийн машин техник, тоног төхөөрөмж, эм хэрэгсэл, хүний нөөцийн хүрэлцээний талаар үнэлгээ хийж, зохицуулалтын арга хэмжээ авах асуудлаар ЭМГ-т даруй мэдээлсэн эсэхийг	1) Үүссэн нөхцөлд эмнэлгийн ор бүрэн дүүрсэн, цаашид нэмэгдэх хандлагатай бол 2) Үйл явдал сумын эрүүл мэндийн төвөөс зайтай, аймгийн эмнэлэгт сумаас болон бусад газраас үйлчлүүлэгчийг тээвэрлэж ирэхэд эмнэлгийн зориулалтын машин техник, хүргэлтийн үед тусламж үйлчилгээ үзүүлэх хөдөлгөөн хязгаарлах чиг, бэхэлгээнүүд, цус тогтоох хэрэгсэл, хүчилтөрөгчийн хангалт дутагдалтай бол 3) Хүний нөөцийн хангалт, эм хэрэгслийн хүрэлцээ, хангамж хомс, дутагдалтай бол 4) Голомтод хариу арга хэмжээг зохион байгуулсан, эрсдэлийг бууруулах, голомтыг цомхотгох талаар авсан арга хэмжээний талаар
5.	Тохиолдлын тоо олон үед эрэмбэлэн ангиллыг зөв хийж, тусламж үйлчилгээний шуурхай	Эрэмбэлэн ангилал нь эмчилгээ биш бөгөөд тусламжийг чиглүүлэх арга хэмжээ тул улаан, шар, ногоон, цагаан зарчмыг баримтлана.

	байдлыг хангаж, үзүүлсэн эсэхийг	
6.	Үйлчлүүлэгчийн оношлогоо, эмчилгээний асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмч мэргэжилтэний зөвлөгөө туслалцаа авч ажилласан эсэхийг	Осол гэмтэл, хордлого, халдварын үед анхны тусламжийг цаг алдалгүй авч лавшруулсан тусламжийг дараахь байдлаар зохион байгуулсан байх. Үүнд: 1) Эм, химийн бодисын хордлого болон шалтгаан тодорхойгүй хордолтын үед нарийн мэргэжлийн эмч нараас зөвлөгөө авч хор саармагжуулах, антидот эмчилгээг хийсэн байх 2) ХХДӨ-ий үед Журам, заавар батлах тухай ЭМС-ын 2017 оны 328 тоот тушаалыг баримтлан ажилласан байна. 3) Осол гэмтэл /хөлдөлт, түлэгдэл, хугарал, бэртэл/-ийн үед гэмтэл, гэмтлийн мэс заслын эмч нараас зөвлөгөө авсан байх, тээвэрлэлтийн горимыг баримталсан байдал 4) Амь тэнссэн, сэхээн амьдруулах, яаралтай тусламжийн чиглэлээр мөн зөвлөгөө туслалцаа авч ажилласан байдал
7.	Аливаа осол гэмтэл, хордлого, халдварын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал бүрэн хангагдсан эсэхийг	Түргэн тусламжийн авто машин нь : 1) Хэвтрийн байрлалд хүн тээвэрлэхээр зориулалттай 2) Хүчилтөрөгчийн хангалт хийхүйц 3) Амьсгалын аппарат 4) Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 5) Дефибрилятор 6) АМБУ 7) Хяналтын монитор 8) Осол гэмтлийн чиг, бэхэлгээнүүд 9) Зөөврийн цахилгаан үүсгэвэр 10) Отсос 11) Зөөврийн дамнуурга Эмчийн цүнхэнд Яаралтай тусламжийн эм хэрэгсэл, ороох боох материал хүрэлцэхүйц тоо, хэмжээгээр байна.
8.	Үүссэн нөхцөл байдалд байгууллагын нөөцийн болон үйл ажиллагааны байдалд эрсдэлийн үнэлгээ хийж хариу арга хэмжээний алхам /яаралтай, шууд, уртасгасан арга хэмжээ/-уудыг хэрэгжүүлсэн эсэхийг	1) Эмнэлгийн нэгдсэн зохион байгуулалт 2) Мэдээ, мэдээллийн урсгал 3) Эмнэлгийн хүчин чадал 4) Хүний нөөцийн хүрэлцээ, мэргэжлийн чадамж 5) Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хүрэлцээ, хангамж, ажиллагаа 6) Лабораторийн оношлогооны чадамж 7) Холбоо мэдээллийн хэрэгслийн хангамж, ажиллагаа 8) Нэмэлт цахилгааны үүсгэвэр 9) Түр байршуулах, нэмж дэлгэх орон байр 10) Шатах тослох материалын нөөц, хүрэлцээ 11) Ажиллагсад болон үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдал

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүснэгт 3-д заасны дагуу хяналт шалгалт хийх;

1. Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн анхны мэдээллийг үндэслэн нөхцөл байдлын үнэлгээ хийж, Эрүүл мэндийн яаманд мэдээлсэн эсэх;

2. Анхан шатны нэгжийн авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний байдлыг тандаж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан эсэх;

3. Шаардлагатай хариу арга хэмжээний багийг томилж ажиллуулсан эсэх;

4. Хариу арга хэмжээний чадамжаас хэтэрсэн зарим арга хэмжээг холбогдох нэгжүүдтэй хамтарч судалгааг өргөтгөх, бусад лабораториудыг түшиглэн оношийг магадлан баталгаажуулах арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх;

5. Шаардлагатай үед холбогдох онцгой комисст асуудлыг тавьж шийдвэрлүүлж ажилласан эсэхийг тус тус шалгах.

№	Асуудал	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1.	Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн анхны мэдээллийг үндэслэн нөхцөл байдлын үнэлгээ хийж, мэргэжлийн төв байгууллага /ЭМЯ/-д мэдээлсэн эсэхийг	Анхан шатны нэгжээс ирүүлсэн үйл явдлын мэдээллийг үндэслэн: 1) Үйл явдал /осол, гэмтэл, хордлого, халдвар/-ын талаарх мэдээллийг нягталсан байх 2) Тохиолдол дэгдэлт болон цар хүрээний байдал, тархалт, өрнөл, эрсдэлийг үнэлсэн байх 3) Эмнэлгийн хүчин чадал, нөөцийн байдлыг үнэлсэн байх 4) Голомтод хариу арга хэмжээг зохион байгуулсан, эрсдэлийг бууруулах, голомтыг цомхотгох талаар авсан арга хэмжээ авсан байх 5) Үйл явдлын хүрээнд сэтгэл зүйн тусламж авах чиглэлээр зохицуулалт хийсэн байх
2.	Анхан шатны нэгжийн авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний байдлыг тандаж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан эсэхийг	1) Үйл явдлын талаарх анхны мэдээ, мэдээллийг хүлээн авч, эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал 2) Тусламж үйлчилгээнд шаардлагатай нөөцийн хүрэлцээг судалж, дэмжих чиглэлээр авсан арга хэмжээ 3) Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаанд зөвлөгөө туслалцаа үзүүлсэн байдал 4) Шаардлагатай үед нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөө туслалцаа авах нөхцөлийг бүрдүүлсэн байх 5) Лабораторийн шинжилгээг өргөтгөх арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээ авсан байх
3.	Шаардлагатай хариу арга хэмжээний багийг томилж ажиллуулсан эсэхийг;	1) Анхан шатны нэгжид үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах болон тандалт судалгаа хийх багийг томилсон байх 2) Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаанд зөвлөгөө туслалцаа үзүүлж, шаардлагатай нарийн мэргэжлийн эмч нарын багийг томилж ажиллуулах арга хэмжээ авсан байх 3) Оношлогоо эмчилгээний асуудлыг шийдвэрлэх зорилгоор шаардлагатай лабораторийн баг ажиллуулах арга хэмжээ авсан байх 4) Химийн бодисын хордолтын үед шаардлагатай тохиолдолд олон улсын итгэмжлэгдсэн лабораторит дээж илгээх асуудлыг шийдвэрлэх
4.	Хариу арга хэмжээний чадамжаас хэтэрсэн зарим арга хэмжээг холбогдох нэгжүүдтэй хамтарч судалгааг өргөтгөх, бусад лабораториудыг түшиглэн оношийг магадлан баталгаажуулах арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэхийг	1) Үйл явдлын цар хүрээ нэмэгдэж, тохиолдлын тоо буурахгүй, эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлаас давсан үед 2) Тохиолдлын тоо цөөн хэдий ч асуудал ноцтой үед 3) Оношлогоо эмчилгээний асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай лабораторийн шинжилгээ хийх, нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллуулах арга хэмжээ авсан байх 4) Химийн бодисын хордолтын үед шаардлагатай тохиолдолд олон улсын итгэмжлэгдсэн лабораторит дээж илгээх асуудлыг шийдвэрлэх
5.	Шаардлагатай үед холбогдох онцгой комисст асуудлыг тавьж шийдвэрлүүлж ажилласан эсэхийг	1) Үйл явдлын цар хүрээ нэмэгдэж, тохиолдлын тоо буурахгүй 2) Тохиолдлын тоо цөөн хэдий ч асуудал ноцтой үед 3) Хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоох асуудлыг тавьж шийдвэрлүүлсэн байх

5.2.3.3.3. Эм биобэлдмэлийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

Эмнэлгүүдэд:

1. Хүний халдварт өвчин, зоонозын шалтгаант халдварт өвчин, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед эмнэлгүүдэд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний эм, эмнэлгийн хэрэгсэл бэлэн байгаа эсэхэд хяналт тавьж, зөвлөнтуслах;

2. Хүний халдварт өвчин, зоонозын шалтгаант халдварт өвчин, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед яаралтай тусламжийн эмийг худалдан авах болон эмийн тасалдал үүсэх үед шаардлагатай арга хэмжээ авч эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн, эмчилгээ сувилгаанд хэрэглэх эм хэрэгслийн бэлэн байдлыг хангасан эсэхэд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3. Хүний халдварт өвчин, зоонозын шалтгаант халдварт өвчин, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үе, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед яаралтай тусламжийн болон эмчилгээ сувилгаанд хэрэглэх эм хэрэгсэл дутагдаж тасалдах нөхцөл үүсч эхлэхэд орон нутгийн Эрүүл мэндийн газартаа мэдэгдсэн эсэхэд хяналт тавьж, зөвлөн туслах;

4. Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед цус цуглуулах хүүдий, оношлуур, эм урвалж, сэлбэх системээр хангагдсан эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

5. Байгалийн аюулт үзэгдэл гамшгийн үед цус орлох бэлдмэлүүдийн хүрэлцээтэй нөөцийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх /Төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, клиникийн болон аймаг, дүүрэг, сумын эмнэлэг, төвүүдэд/;

6. Эмийн хордлогын үед шаардлагатай антидот, хор саармагжуулах бодис шаардлагатай байгаа талаар орон нутгийн Эрүүл мэндийн газарт мэдэгдсэн эсэхэд хяналт тавьж, зөвлөн туслах;

7. Эмийн хордлогын үед шаардлагатай антидот, хор саармагжуулах бодис хүрэлцэхүйц хэмжээтэй байгаа эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх /Эмнэлэг нь Цэргийн төв эмнэлгийн Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвөөс арга зүйн зөвлөлөгөө авсны дагуу антидот, хор саармагжуулах бодисыг бэлэн байлгах/.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв /орон нутгийн/ байгууллагад:

1. Хүний халдварт өвчин, зоонозын шалтгаант халдварт өвчин, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед эмнэлгүүдийн яаралтай тусламжийн болон эмчилгээ сувилгаанд хэрэглэх эм хэрэгсэл дутагдаж тасалдах нөхцөл үүсч эхлэхэд эм хэрэгслийн хангамжийн асуудлыг зохион байгуулж ажилласан эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөлөгөө өгөх;

2. Хүний халдварт өвчин, зоонозын шалтгаант халдварт өвчний дэгдэлтийн үе, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед вакцин биобэлдмэлийн нөөц бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж, зөвлөн туслах;

3. Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед цус цуглуулах хүүдий, оношлуур, эм урвалж, сэлбэх системийн нөөц бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж, зөвлөн туслах;

4. Эмийн хордлогын үед шаардлагатай байгаа антидот, хор саармагжуулах бодисыг эмнэлгүүдэд бэлэн байлгах ажлыг зохион байгуулсан эсэхэд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.

5.2.3.3.4. Хүнсний чанар, стандартын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

А. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед:

1. Хүнсний түүхий эдийн анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон тэдгээрийг хадгалах, тээвэрлэх, худалдах, үйлчлэх, хүнсийг савлах, шошголох зэрэг хүнсний сүлжээний үе шатанд гарсан эрсдэлийг тооцож бүртгэл, тэмдэглэлүүдийг нарийвчлан шалгах;
2. Бүтээгдэхүүний орц найрлагад орсон түүхий эдийн жагсаалтыг нарийвчлан гаргаж, технологийн зааварт тусгагдсан орц, хэмжээг баримталсан эсэх, эгзэгтэй цэгийн хяналтыг тусгасан эсэх, бүртгэлжүүлсэн байдлыг тулгаж хянах;
3. Хоол, хүнсний хордлого, халдвар гарсан үед тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийлүүлсэн, үйлдвэрлэсэн тоо хэмжээ, нэр төрөл, гарал үүсэл, цувралын дугаар, хадгалах хугацаа, түгээсэн байдалд ул мөрийг мөрдөн тогтоох, эрсдэлийг тооцох;
4. Хүнсний үйлдвэрлэл үйлчилгээг эрхлэгч нь өөрт хамаарах сүлжээнд хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах үүсч болох эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлж, тогтмол хэрэгжүүлж буй байдлыг шалгаж тогтоох;
5. Үүссэн нөхцөлтэй уялдуулан хүнсний үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл, анхан шатны бүртгэл, тэмдэглэл өдөр тутамд хөтлөж буй эсэхэд хяналт шалгалт хийх;
6. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй байр, өрөө тасалгааны байршил, технологи урсгал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ явуулах шаардлага хангаж байгаа эсэхэд шалгалт хийх;
7. Хоол, хүнсний үйлдвэрлэлд хэрэглэж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь үйлдвэрлэж байгаа хүчин чадалд тохирч байгаа эсэхийг шалгах;
8. Хоол, хүнс үйлдвэрлэх технологийн горимын мөрдөлт, шат дамжлага бүрт хяналт тавьж бүртгэл хөтөлсөн эсэх;
9. Хоол, хүнс үйлдвэрлэж буй хүнсний түүхий эд, хүнсний нэмэлт болон баяжуулагч бодис, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын баталгаажилттай эсэх, тэдгээрийн зарцуулалтын бүртгэл хөтлөлт, түүний хадгалалт, тээвэрлэлт, худалдаалалтын байдалд хяналт шалгалт хийх;
10. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав баглаа, боодол нь зориулалтын эсэх, лабораторийн шинжилгээний бичигтэй эсэх, савлах, хаяглах, шошгод агуулагдах мэдээллийг бүрэн тусгасан эсэх, буруу шошголсон эсэхэд шалгалт хийх;
11. Бүтээгдэхүүнийг зах зээлээс буцаан болон татан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж устгасан бүтээгдэхүүний бүртгэл тэмдэглэлийг шалгах;
12. Дотоод хяналтын нэгж буюу ажилтан нь дотооддоо хяналтыг хэрэгжүүлж, шалгалтын үр дүнгээр хийж буй ажил, урьд өмнө нь гарч байсан зөрчил түүнийг хэрхэн арилгасан талаарх байдлыг шалгах.

5.2.3.3.5. Мал эмнэлгийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

А. Мал, амьтны гоц халдварт өвчний үед:

1. Мал, амьтанд эмнэл зүйн үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээний сорьц авч, илгээх;
2. Голомтын болон бусад бүсийн мэдрэмтгий мал, амьтны дархлаажуулалтын явцад хяналт тавих;
3. Өвчний ил шинж тэмдэгтэй болон лабораторийн шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн мал, амьтанд ялган тэмдэглэгээ хийж, малчдад заавар, зөвлөгөө өгөх;

4. Голомтын бүс дэх хашаа, хороо, уст цэг, малын тоног хэрэгслийн халдваргүйтгэлд хяналт тавих;

5. Зайлшгүй шаардлагаар төхөөрсөн, устгасан мал, амьтны биологийн хаягдал, хүүр, сэг зэмийг устгах цэг тогтооход хяналт тавих;

6. Шалган нэвтрүүлэх цэг, устгалын цэгт хийгдсэн ариутгал, халдваргүйтгэлд хяналт тавих;

7. Хорио цээрийн бүсийн хилийн зааг дээр таних тэмдэг байрлуулах, уг бүсийн хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;

8. Хорио цээрийн бүсийн хилийн зааг авто замын гол чиглэлд шалган нэвтрүүлэх цэг байгуулж, хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;

9. Голомтын бүсэд оруулах хүнс, бараа, бусад зүйлийг тогтоосон цэгт тусгайлан бэлтгэсэн талбай /тавцан/-д буулгаж, сэлгүүлэн хүргүүлэх хэлбэрээр зохион байгуулах.

10. Мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлтийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж, менежерээр хянуулах, шаардлагатай тохиолдолд мэдээлэх;

11. Малыг гоц халдварт өвчин тархахаас сэргийлэх арга хэмжээ авч хорио цээр, хязгаарлалт тогтоох санал, дүгнэлтийг менежерт танилцуулж холбогдох газруудад хүргүүлэх;

12. Хорио цээр хязгаарлалтын дэглэм, тухайн өвчинтэй тэмцэх заавар, журам зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах;

13. Гоц халдварт өвчний үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хяналт шалгалтын дүнг нэгтгэн, аймаг, нийслэлд мал эмнэлгийн тархвар судлагч эмчтэй хамтран 3 хоногийн дотор урьдчилсан, 15 хоногийн дотор эцсийн дүгнэлтийг гаргаж, хамтарсан тайлан бичиж, цахим мэдээллийн санд оруулах ба дээд шатны байгууллагад албан бичгээр хүргүүлэх, архивлах;

14. Мал, амьтны гоц халдварт өвчний эцсийн тайланд өвчин гарсан аймаг, сум, баг, хороо, дүүрэг, өвчилсөн, устгасан, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын төрөл, тоо, илэрсэн шинж тэмдэг, өвчин оношлогдсон огноо, шинжилгээ хийлгэсэн лабораторийн нэр, өвчний нэр үүсгэгч болон лавлагаа шинжилгээг хийлгэсэн лабораторийн нэр, эцсийн онош, оношийн баталгаажилт, илрүүлсэн, арилгуулсан зөрчлийн агуулга, тоо, гоц халдварт өвчин гарсан шалтгаан, дамжсан зам, нөлөөлсөн хүчин зүйлд дүн шинжилгээ хийн дүгнэлт гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулах.

Б. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед:

1. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын агуулахад буй мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн/мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүн/-ий хадгалалт стандартын шаардлага хангаж байгаа эсэх;

2. Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авсан болон хадгалалтын горимын бүртгэл;

3. Хэрэглэснээс үлдсэн болон нөөцөд хадгалагдаж буй мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг мэдрэхүйн аргаар шалгах;

4. Гарал үүсэл, мал эмнэлэг, ариун цэврийн баталгаажилтыг шалгах;

5. Холбогдох заавар, журмын дагуу дээж авч, лабораторид хүргүүлэх;

6. Лабораторийн шинжилгээний сорилтын дүн эерэг гарсан тохиолдолд дараагийн шатны арга хэмжээг авна. Үүнд:

6.1. Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлж, ул мөрийг мөрдөн мөшгих;

6.2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтад хамрагдсан байдал;

6.3. Малд эмчилгээ хийлгэсэн эсэх /ямар эмийн бэлдмэл хэрэглэсэн, эмчилгээ хийсэн он, сар, өдөр, эмийн биеэс гадагшлах хугацаа дууссан, улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэх, шинжилгээ баталгаажилтад хамрагдсан эсэх, /

6.4 Хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн нөхцөлийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх.

5.2.3.3.6. Ургамал хорио цээрийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

А. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед:

1. Ургамал хамгааллын химийн бодис, пестицидийн нөлөө, хөнөөлт организм нөлөөлсөн эсэхийг эсвэл ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс хордлого үүсгэсэн эсэхийг тодруулж, тухайн бүтээгдэхүүний гарал үүслийн баталгаажилт, бэлтгэсэн он, сар, өдөр, хадгалах хугацаа, худалдаж авсан он, сар, өдөр, хэмжээ/жин, үйлдвэрлэгч, түгээгч, борлуулагчийн нэр, хаягийг тодруулах;

2. Сэжиг бүхий түүхий эд, бүтээгдэхүүний дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулж, ногоог хаана тарьж ургуулсан болох, ямар бодис, бордоо бэлдмэл хэрэглэсэн болох, пестицид хэрэглэснээс хойш ургац хураах, худалдаанд гаргах, хугацааг сайтар баримталсан эсэхийг судлан магадлаж, хэрэглэсэн бодисын үлдэгдэл бүтээгдэхүүнд үлдсэн эсэх, аюулгүйн шаардлага хангасан эсэхэд шалгаж дүгнэлт өгөх.

5.2.3.3.7. Байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

А. Химийн осол хордлогын үед:

1. Химийн бодисын ослын үед тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ашиглаж байгаа химийн бодисын бүртгэл судалгааг гаргах, хорт болон аюултай бодисыг ашиглах, импортлох, хадгалах тусгай зөвшөөрөлтэй эсэх, агуулах ажлын байр нь стандарт шаардлага хангаж буй эсэхэд хяналт шалгалт хийх;

2. Химийн бодисын аюулгүйажиллагааны зааварчилгаа, ослын үед ажиллах төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулсан эсэх, төлөвлөгөөний дагуу хүн нэг бүрийг хамгаалах хувцас хэрэгслээр хангасан, монгол нэр, олон улсын нэр, томъёо, CAS дугаар, хаяг шошго, эрүүл мэндэд нөлөөлөх зэрэглэл, гал авалцах зэрэглэл, хор аюулын тэмдэглэгээ, урвалд орох зэрэглэл зэрэг үзүүлэлтээр нь ангилан хадгалсан эсэхэд хяналт шалгалт хийх;

3. Химийн бодисын осол, хордлого гарсан бүс нутагт Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн онцгой байдлын газраас химийн бодисыг саармагжуулалт, цэвэрлэгээ хийсний дараа хяналтын болон бохирдсон орчноос дээж авах талаар орчны эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчтай мэдээлэл солилцох;

4. Химийн хорт болон аюултай бодисын осол аваргийн үед саармагжуулах арга хэмжээгхор аюулын лавлах мэдээллийг үндэслэн боловсруулсан эсэхэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд Химийн хорт болон аюултай бодисын зөвлөлөөс дэмжлэг авах талаар санал хүргүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

5. Химийн бодисын ослын үед Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн онцгой байдлын газраас химийн бодисын саармагжуулалт, цэвэрлэгээ хийсний дараа үүсч буй аюултай хог хаягдлыг хэрхэн саармагжуулах, түр хадгалах, устгах, эрх бүхий байгууллагад шилжүүлэх арга хэмжээнд хяналт тавьж ажиллах;

6. Багийн ахлагчийг үнэн зөв, бодитой мэдээллээр шуурхай хангаж ажиллах, химийн бодисын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тэргүүлэгч байгууллагатай хамтран ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.

5.2.3.3.8. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг:

А. Химийн осол, хордлогын үед:

1. Ажлын байранд алдагдсан химийн бодисыг тухайн химийн хорт болон бодисын хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн саармагжуулах, хоргүй болгох үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
2. Ажлын байр, тоног төхөөрөмж, агаар сэлгэлтийн систем, химийн бодисын хадгалалт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа, хувийн хамгаалах хувцас, хэрэглэлийн байдалд хяналт шалгалт хийх,
3. Ажлын байрны агаар дахь химийн бодисын ууршилтыг лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргах;
4. Химийн бодисын нөлөөллөөс ажилтнууд, ард иргэдийг сэргийлэхэд тэргүүлэгч байгууллагатай хамтран ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
5. Химийн бодисын хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагаас гаргасан болон өөрийн боловсруулсан зөвлөмж, сэрэмжлүүлгийг түгээх, сургалт, сурталчилгааг идэвхитэй хийх;
6. Химийн бодисын хордлогын голомтод ажиллах байгууллагын ажилтны хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийг тогтоох, захиалахад хамтран ажиллах;
7. Орон нутгийн нөөцөд байгаа саармагжуулах бодис, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.

Б. Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед:

1. Газар хөдлөлт, гамшиг болсон газрын талаар мэдээлэл авч хурц хордлогод өртсөн осолдогч нарт "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн дагуу ослын акт тогтоох.

5.2.3.3.9. Дэд бүтцийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

Б. Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед:

1. Үйл явдлын анхны мэдээллийг салбар хоорондын байгууллагаас түрүүлж авсан бол мэдээллийг нягтлах, авсан мэдээллээ цахим мэдээллийн санд /EBS/ оруулах;
2. Орон нутгийн салбар хоорондын багийн бүрэлдэхүүнд орж ажиллах;
3. Багийн ахлагчийг үнэн зөв, бодитой мэдээллээр шуурхай хангаж ажиллах;
4. Орон нутгийн барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээнд үүссэн нөхцөл байдлыг тодорхойлж, тогтоох, онцгой байдлын болон дэд бүтцийн холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах;
5. Ашиглаж байгаа барилга байгууламжууд, авто замын чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
6. Байгалийн гамшгийн үед дэд бүтцийн салбарт ажиллагсад, иргэд оршин суугчдад урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмж өгөх, хэрэгжилтэд нь хяналт тавих;
7. Байгалийн гамшгийн үед дэд бүтцийн хяналтын улсын байцаагчид шаардлагатай дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, баталгаажуулах;
8. Барилга байгууламж, авто замын ашиглалт, үйл ажиллагаа хариуцсан холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцож, үүссэн нөхцөл байдалд хамтран ажиллах;
9. Гамшигт өртсөн авто зам, барилга байгууламжуудад хамгаалалт, аюулгүйн бүс тогтоож хяналт тавьж ажиллах;
10. Барилга байгууламж, авто замд гарсан эвдрэл гэмтэл, нуралтаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлгийг түгээх, аюулгүйн сургалт, сурталчилгааг хийх;

11. Гамшигт өртсөн барилга байгууламжаас хүн амыг гаргах, зөөн тээвэрлэх талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх;

12. Нийтийг хамарсан үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээ авсан үед хэрэгжилтэд хяналт тавих.

5.2.3.3.10. Хилийн нэвтрэх цэгт хэрэгжүүлэх хариу арга хэмжээ

1. Удирдлага, зохион байгуулалт

1.1. Хилийн нэвтрэх цэгт болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээг Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор хэрэгжүүлнэ.

1.2. Хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүнд үйл явдлын төрлөөс хамааран энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан зааварт тусгасан бүдүүвч 1-10-д заасан албан тушаалтан орж ажиллана

1.2.1. Тохиолдлын удирдлагын зохицуулагч нь Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга, хилийн хэлтэс бүхий аймагт Аймгийн мэргэжлийн хяналтын газрын дарга, менежер нь ХМХА-ны Хяналт шалгалтын хэлтсийн дарга болон хилийн боомт дахь Хэлтсийн дарга байна.

1.2.2. Тохиолдлын удирдлагын багийн ахлагч нь үйл явдлын төрлөөс хамаарч тухайн чиглэлийн улсын /ахлах/ байцаагч байна.

1.3. Хилийн нэвтрэх цэгт болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хил хамгаалах, гааль, иргэний харьяат зэрэг хил, хяналтын болон аюулгүй байдлын алба, тээвэр, ложистикийн байгууллагуудтай "Бэлэн байдлын төлөвлөгөө"-ний дагуу хамтарч ажиллана.

1.4. Хилийн нэвтрэх цэгт цацрагийн осол, хордлого гарсан үед энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтын 5.1.2.3.4-д заасны дагуу хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2. Хариу арга хэмжээ

А. Хүний халдварт өвчин, зоонозын шалтгаант халдварт өвчний үед:

Хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

1. Онгоцны экипаж, галт тэрэгний дарга, ахлах үйлчлэгч, автомашины жолоочоос зорчигчийн тоо, суудлын дугаар бүхий нэрсийн жагсаалт, ерөнхий мэдүүлгийг авч, эрүүл мэндийн тандалтыг эхлэх;

2. Цахим програмын /APIC/ тусламжаар зорчигчийн урьдчилсан мэдээллийг авах, зорчигчид ажиглалт хийх /харааны эрт илрүүлэлт/, халуун хэмжих төхөөрөмж болон багажийн тусламжтайгаар биеийн халууныг хэмжих /халууны эрт илрүүлэлт/ үйл ажиллагааг явуулах;

3. Хилийн нэвтрэх цэгийн тусгаарлах өрөөний зохион байгуулалт, тавигдах шаардлага, шаардлагатай тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, эмийн жагсаалтыг энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтад заасны дагуу бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;

4. Халдварт өвчний сэжигтэй зорчигч илэрсэн үед холбогдох байгууллагад "Схем 3"-ын дагуу мэдээллийг дамжуулж, EBS програмд мэдээллийг оруулах;

5. Халдварт өвчний сэжигтэй зорчигчийн биеийн халууныг хэмжин баталгаажуулж, зорчигч болон хавьтагсдад амны хаалт зүүлгэх;

6. Тээврийн хэрэгсэл доторхи хөдөлгөөнийг хязгаарлаж, зорчигч орж, гарахыг хориглох арга хэмжээг авах;

7. Халдварт өвчний сэжигтэй зорчигчийг түр тусгаарлан, эмнэл зүйн шинж тэмдгийг сайтар нягтлан үзэж, энэхүү тушаалын тавдугаар хавсралтаар баталсан "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг" /health declaration form of passengers/-ийг

бөглүүлж, цахим хэлбэрээр мэдээллийн сан үүсгэн, цаасан хэлбэрээр хадгалж, тандалт хийх;

8. Сэжигтэй өвчтөнд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;

9. Сэжигтэй өвчтөнөөс хамар залгиурын арчдас, цусны дээж гэх мэт шинжлэгдэхүүн авч, лабораторид шинжлүүлэх;

10. Ойрын хавьтлыг тогтоон бүртгэн, “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг” бөглүүлж, биеийн халууныг хэмжих;

11. Шаардлагатай тохиолдолд ойрын хавьтлыг түр тусгаарлан, сэжигтэй зорчигч болон ойрын хавьтлыг төвийн түвшинд ХӨСҮТ-ийн мэргэжлийн баг, аймаг, орон нутгийн түвшинд эмнэлгийн байгууллагын мэргэжлийн багийг дуудан эмнэлэгт шилжүүлэх;

12. Сэжигтэй зорчигч, хавьтагсдыг эмнэлгийн байгууллагад хүргэсний дараа тээврийн хэрэгсэл, тусгаарлах өрөө, тасалгаанд эцсийн халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх;

13. Бусад зорчигч болон тээврийн хэрэгслийн бие бүрэлдэхүүнээр “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг” бөглүүлж, биеийн халууныг хэмжин, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад хандах өрхийн эмнэлэг болон бусад шатлалын эмнэлгийн хаяг, холбогдох утасны дугаарыг өгөх;

14. Тухайн халдварын талаарх зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээллээр зорчигч, онгоц, галт тэрэг, автомашины багийн бүрэлдэхүүн, хил хяналтын болон бусад хамтран ажилладаг байгууллагыг тогтмол хангах;

15. Тусгаарлах өрөөний багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг хангалт, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, эмийн чанар, аюулгүй байдалд холбогдох чиглэлийн улсын /ахлах/ байцаагчтай хамтран хяналт тавих;

16. Хилийн боомтын цогцолборын өрөө, тасалгаа, онгоц, галт тэрэг, автомашин, зорчигч, үйлчилгээний төвийн халдваргүйтгэл, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих;

17. Халдварын сэжигтэй материалууд, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг халдвар эсэргүүцэх дэглэмийн дагуу устгуулах арга хэмжээ авах;

18. Халдварын судалгаа, эмнэл зүйн шинж тэмдэг, халдварын эх уурхай, дамжсан зам, хөл хорионы хамрах хүрээ, хугацааг тогтоож цаашид авах арга хэмжээний саналыг менежерт танилцуулж шийдвэрлүүлэх;

19. Хил, хяналтын бусад байгууллагыг мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, хамтран ажиллах;

20. Үүссэн нөхцөл байдлын эрсдэлийн харилцааны талаарх мэдээллээр менежерийг тогтмол хангаж ажиллах;

21. Хариу арга хэмжээг зохион байгуулсан тайлан, зарцуулсан хөрөнгө, зардлын тооцоог гаргаж, менежерт танилцуулж, шийдвэрлүүлэх;


22. Шаардлагатай тохиолдолд хорио цээрийн хязгаарлалтын дэглэм зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах;

23. Хил залгаа хөрш улсын боомтын хорио цээрийн байгууллагад өвчний талаархи мэдээллийг хүргүүлэх эсэх асуудлыг менежер, зохицуулагчид тавьж шийдвэрлүүлэх;

24. Тухайн нөхцөл байдал гүний хяналтын бүс, талбай /терминал/-д үүсвэл энэхүү зааврын дагуу хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

25. Улсын /ахлах/ байцаагч, ажилтан нь 24 цагийн турш гар утсыг нээлттэй байлгаж, хариу арга хэмжээний тайланг менежер, зохицуулагчид тогтоосон хугацаанд ирүүлэх.

ХИЛИЙН НЭВТРЭХ ЦЭГТ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ СХЕМ



Б. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед:

Хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд хоол хүнснээр дамжих өвчний дэгдэлт гарсан үед энэхүү зааврын 5.2.3.3.1 дэх хэсгийн Б-д зааснаас гадна дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Сэжигтэй зорчигчийг харъяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлж, түр тусгаарлах арга хэмжээ авах;
2. Зорчигчийн хоолны ханган нийлүүлэлт, үйлдвэрлэсэн огноо, тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл, хоолны сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал, зориулалтын сав баглаа боодол эсэх, онгоц, галт тэрэгний усны чанар, аюулгүй байдал, хооллох хэрэгслийн угаалга, цэвэрлэгээний байдалд тус тус хяналт шалгалт хийх;
3. Зорчигчийн хоолыг бэлтгэсэн катеринг болон хоол үйлдвэрлэлийн газарт байнгын хяналт тавьж ажилладаг тухай орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад үйл явдлыг мэдээлж хамтарсан хариу арга хэмжээ авах;
4. Сэжигтэй зорчигчийг эрүүл мэндийн байгууллага ирэх хүртлэх хугацаанд ЭМС-ын 2017 оны “Журам, заавар шинэчлэн батлах тухай” 328 дугаар тушаалын Маягт №3-аар батлагдсан “ХХДӨ-ний тархвар судлалын судалгааны хуудас”, энэхүү тушаалын тавдугаар хавсралтаар баталсан “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”-ээр тус тус тандалт судалгаа авах;
5. Сэжигтэй зорчигчоос хоолны үлдэгдэл, бөөлжис, ялгадас зэрэг шаардлагатай шинжлэгдэхүүнийг дээрх тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Сорьц, шинжлэгдэхүүн цуглуулах ба түүнтэй харьцах заавар”-ын дагуу авч, лабораторийн шинжилгээнд хүргүүлэх;
6. Хилийн боомт, гаалийн хяналтын бүс, тээврийн хэрэгсэлд хийх ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэл, бохир усны зайлуулалтын байдалд хяналт тавих;
7. Сэжигтэй зорчигчийг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлсний дараа тусгаарлах өрөө, хүрэлцсэн талбай, орчинд эцсийн ариутгал, халдваргүйтгэлийг хийлгүүлэх;
8. Импортын хүнстэй холбоотой ХХДӨ-ний дэгдэлт хилийн нэвтрэх цэгт гарсан тохиолдолд хилээр нэвтрүүлэх үед хяналт шалгалтад хамрагдсан эсэх, гарал үүсэл, баримт бичгийн бүрдэл, үйлдвэрлэгч, импортлогч, тээвэрлэгчийн талаарх эрсдэлийн түүх, мэдээллийг цахим мэдээллийн сангаас авч, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ашиглах;
9. Хариу арга хэмжээний үед эрсдэлийн харилцаа холбоог идэвхжүүлэн ажиллаж, явцын болон эцсийн тайланг менежерт танилцуулж ажиллах.

В. Мал амьтны гоц халдварт өвчний үед:

Хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсийн мал эмнэлгийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг:

1. Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн бүсэд мөрдөх дүрэм, журам, заавар, стандарт, ариун цэврийн дэглэмийг шуурхай хэрэгжүүлэх;
2. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн дэглэмийн талаар иргэд, олон нийтэд сурталчлах, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгөх;
3. Өвчний сэжигтэй мал, амьтан, түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын байранд түр саатуулах;
4. Өвчний цагийн байдлын талаархи мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шуурхай дамжуулах;
5. Сэжигтэй мал, амьтан, түүхий эд, бүтээгдэхүүнээс лабораторийн шинжилгээний дээж авч, итгэмжлэгдсэн лабораторид битүүмжлэн илгээх;
6. Хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтаар өвчний шинж тэмдэг илэрсэн, гэмтэж муудсан нь тогтоогдсон түүхий эд, бүтээгдэхүүнийг

улсын /ахлах/ байцаагч 21 хүртэл хоногийн хугацаагаар түр саатуулж, хорио цээрийн дэглэмд оруулах, энэ тухай мэдэгдлийг хариуцагч иргэн, хуулийн этгээдэд хүргүүлэх;

7. Өвчний ил шинж тэмдэгтэй болон лабораторийн шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн мал, амьтанд ялган тэмдэглэгээ хийж, хяналт хийх;

8. Зайлшгүй шаардлагаар устгах мал, амьтан болон түүхий эд, бүтээгдэхүүн, малын сэг зэмийг устгах, булшлах, халдваргүйтгэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

9. Өвчний сэжигтэй мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон тээврийн хэрэгсэл, хашлага бусад зүйлд холбогдох мэргэжлийн байгууллагаар эмчилгээ, ариутгал, халдваргүйтгэл хийлгүүлж, хяналт тавих;

10. Малын гоц халдварт өвчин тархахаас сэргийлэх арга хэмжээ авч хорио цээр, хязгаарлалт тогтоох санал, дүгнэлтийг менежерт танилцуулж холбогдох газруудад хүргүүлэх;

11. Шаардлагатай тохиолдолд хорио цээр хязгаарлалтын дэглэм, тухайн өвчинтэй тэмцэх заавар, журам зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах;

12. Гоц халдварт өвчний үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хяналт шалгалтын дүнг нэгтгэн 3 хоногийн дотор урьдчилсан, 15 хоногийн дотор эцсийн дүгнэлтийг гарган, тайлан бичиж, цахим мэдээллийн санд оруулах ба дээд шатны байгууллагад албан бичгээр хүргүүлэх, архивлах;

13. Хил залгаа хөрш улсын боомтын хорио цээрийн байгууллагад өвчний талаархи мэдээллийг хүргүүлэх эсэх асуудлыг менежер, зохицуулагчид тавьж шийдвэрлүүлэх.

Г. Химийн осол, хордлогын үед:

Хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсийн байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

1. Химийн бодистой холбоотой гамшиг, ослын тухай анхны мэдээллийг бусад байгууллагаас түрүүлж авсан бол мэдээллийг нягтлах, нэмэлт мэдээллийг тээвэр зууч, тээврийн хэрэгслийн жолооч, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлж буй иргэнээс тодруулах;

2. Ослын үед асгарч, алдагдсан бодисын нэр төрөл, хэмжээ, физик, химийн шинж чанар, хүн, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаарх мэдээллийг судлах;

3. Тээвэрлэж буй бодисын нэр, НҮБ-ын дугаар, хэмжээ, асгарч алдагдсан болон галд өртсөн бодисын нэр, хэмжээ, осол аваар гарсан шалтгаан, сав, баглаа, боодол болон тээврийн хэрэгслийн нөхцөл байдал, байршил, хүний эрүүл мэндэд нөлөөлсөн бол өртсөн болон нас барсан хүний тоо, гал унтраах болон цэвэрлэх, хоргүйжүүлэхэд шаардагдах бодис, материал зэрэг мэдээллийг орон нутгийн цагдаагийн болон онцгой байдлын байгууллагад мэдэгдэх;

4. Боломжтой тохиолдолд орон нутгийн онцгой байдлын болон цагдаагийн байгууллагын ажилтнууд ирэх хүртэл химийн бодисын асгаралт, алдагдлыг таслан зогсоох, тухайн үйл явдал болсон газрыг тусгаарлах анхан шатны арга хэмжээг авахуулах;

5. Орон нутгийн салбар хоорондын багийн бүрэлдэхүүнд орж ажиллах;

6. Багийн ахлагчийг үнэн зөв, бодитой мэдээллээр шуурхай хангаж ажиллах;

7. Асгарч, алдагдсан химийн бодисын хор, аюулаас зорчигч, ажилтнуудыг хамгаалах арга хэмжээг тэргүүлэгч байгууллагатай хамтран зохион байгуулах;

8. Химийн бодисын нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж, сэрэмжлүүлгийг боловсруулж холбогдох иргэд, ажилтнуудад түгээх;

9. Ослын голомтод ажиллах багийн бүрэлдэхүүний нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаа, зориулалт, аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөгөө өгөх;

10. Асгарч, алдагдсан химийн бодисыг цэвэрлэх, хоргүйжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх.

Хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн үүрэг

1. Энэхүү зааврын 5.2.3.3.1 дэх хэсгийн В-д заасны дагуу хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2. Химийн осол, хордлогод өртсөн орчны агаар, хөрснөөс дээж авч, лабораторийн шинжилгээнд хамруулан, дүгнэлт гаргах.

Д. Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн үед:

Хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд байгалийн аюулт үзэгдэл, гамшиг тохиолдсон үед “Бэлэн байдлын төлөвлөгөө”-ний дагуу холбогдох хяналтын чиглэлийн улсын /ахлах/ байцаагчид хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.2.3.3.11. Хариу арга хэмжээний багийн гишүүдээс бусад байцаагч, ажилтнуудын үүрэг

1. Мэргэжлийн байгууллага, эрсдэлийн мэдээлэл, харилцааны багаас гаргасан зөвлөмж, сэрэмжлүүлгийг зорилтот бүлэг, олон нийтэд түгээх;

2. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажил үүргээ хэрэгжүүлэх;

3. Хариу арга хэмжээний багийн гишүүдийг орлон ажиллах нөөцөд бүртгэгдсэн бол бэлэн байдлыг хангах;

4. Шаардлагатай тохиолдолд хариуцлагатай жижүүрт ажиллах болон тухайн орон нутгаар дайрч өнгөрөх улсын чанартай авто замын шалган нэвтрүүлэх товчоо, гарцууд дээр хийх хяналт шалгалтын болон бусад ажилд дайчлагдах.

5.2.4. Эрсдэлийн мэдээлэл, харилцааны багийн үүрэг

1. Эрсдэлийн мэдээлэл, харилцааны баг нь төвийн түвшинд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга /багийн ахлагч/, эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга, олон нийттэй харилцах мэргэжилтэн, гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн, шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээний багийн ахлагчаас бүрдэнэ.

2. Эрсдэлийн мэдээлэл, харилцааны баг нь салбар хоорондын эрсдэлийн мэдээлэл, харилцааны багтай хамтран олон нийтэд хүргэх мэдээллийн стратеги, төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэх;

3. Мэдээллийг эрсдэлийн түвшин өөрчлөгдөх бүрт шинэчлэн боловсруулж, хүн амд шууд хүргэх оновчтой хувилбараар бэлтгэж, менежерт хянуулах;

4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдэж буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

5. Үүссэн нөхцөл байдалтай холбоотой олон нийтийн санаа бодлыг сонсох, иргэдэд үнэн зөв мэдээлэл өгөх шуурхай утас ажиллуулах;

6. “Бага” эрсдэлтэй үед тухайн чиглэлийн улсын байцаагч, төвийн түвшний олон нийттэй харилцах ажилтан, “дунд” эрсдэлтэй үед тухайн асуудал хариуцсан зохицуулагч, менежер олон нийтэд мэдээлэл өгч ажиллах;

7. Эрсдэлийн түвшин “өндөр” үед холбогдох яамдын сайд, төрийн нарийн бичгийн даргад, “маш өндөр” үед Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын даргад мэдээллийг тухай бүр бэлтгэж хүргүүлэх.

5.2.5. Санхүү, нөөцийн багийн үүрэг

1. Зардлын тооцоог гарган, бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэх;
2. Нөөцийн хуваарилалтыг оновчтой хийх;
3. Зохицуулагчаас ирүүлсэн саналын дагуу санхүү, нөөцийн асуудлыг шуурхай шийдвэрлэх;
4. Шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм урвалж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хувцсаар хангах;
5. Шаардлагатай тохиолдолд санхүүгийн болон эд материалын тооцоог гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх;
6. Ажилтнуудын илүү цагийн хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох эсэхийг шийдвэрлэх;
7. Зарцуулалтын нэгдсэн тайланг гаргаж, зохицуулагчид хүргүүлэх;
8. Бусад шаардлагатай арга хэмжээг тухай бүр нь авч хэрэгжүүлэх.

ЗУРГАА. ЛАБОРАТОРИУДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА

6.1. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын дэгдэлтийн үед улсын /ахлах/ байцаагчид хяналт шалгалтын явцад авсан сорьцыг ХАБҮЛЛ, аймаг, нийслэлийн МХГ-ын лаборатори, хилийн боомт дахь ХМХА, хэлтсийн лаборатори, бусад холбогдох итгэмжлэгдсэн лабораториудад шинжилгээ хийлгүүлж, баталгаажуулах;

6.2. Эрсдэлийн түвшингээс хамааран бага эрсдэлтэй үед ажлын цагаар, дундаас дээш эрсдэлтэй үед аймаг, нийслэлийн МХГ-ын лаборатори, хилийн боомт дахь ХМХА, хэлтсийн лаборатори, ХАБҮЛЛ 24 цагийн тасралтгүй ажиллагааны горимд шилжин ажиллах;

6.3. ХАБҮЛЛ нь бусад лабораториудын шинжилгээний дүнгээр мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, шаардлагатай бэлэн байдлыг хангаж ажиллах;

6.4. Лаборатори бүр хийсэн шинжилгээний дүн мэдээг мэдээллийн нэгдсэн санд тухай бүр оруулах;

6.5. Лабораториуд шаардлагатай тохиолдолд хүний нөөцийн зохицуулалт хийх, тоног төхөөрөмж, эм урвалжийг харилцан солилцон ажиллах, шинжилгээг орлон, хавсран гүйцэтгэх, үр дүнг баталгаажуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллах;

6.6. Лабораториуд нь шинжилгээг стандарт арга, аргачлалын дагуу гүйцэтгэж, урьдчилсан дүнг гарсан даруйд холбогдох чиглэлийн улсын /ахлах/ байцаагчид мэдэгдэж, эцсийн дүнг гармагц хүргүүлэх;


6.7. ХАБҮЛЛ нь итгэмжлэгдсэн лабораториудын сорилтын үр дүнд зөрүү гарсан тохиолдолд маргаан таслах сорилтыг гүйцэтгэх;

6.8. ХАБҮЛЛ нь шинжлэх боломжгүй шинжилгээг тухайн чиглэлээр итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлэх;


6.9. Монгол Улсын хэмжээнд тухайн сорилтыг гүйцэтгэх итгэмжлэгдсэн лаборатори байхгүй болон ХАБҮЛЛ-ийн маргаан таслах шинжилгээний дүнг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд олон улс, бүс нутгийн итгэмжлэгдсэн лабораторит дээжийг хүргүүлж, шинжлүүлнэ.

----- оОо -----


ХҮНИЙ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ ТӨВИЙН ТҮВШНИЙ БҮРЭЛДЭХҮҮН




ХҮНИЙ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ НЭГЖИЙН ТҮВШНИЙ БҮРЭЛДЭХҮҮН




МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ ТӨВИЙН ТҮВШНИЙ БҮРЭЛДЭХҮҮН




МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ НЭГЖИЙН ТҮВШНИЙ БҮРЭЛДЭХҮҮН




ХООЛ ХҮНСЭЭР ДАМЖИХ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ ТӨВИЙН ТҮВШНИЙ БҮРЭГЛДЭХҮҮН




ХООЛ ХҮНСЭЭР ДАМЖИХ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ НЭГЖИЙН ТҮВШНИЙ БҮРЭЛДЭХҮҮН




ХИМИЙН БОДИСЫН ОСОЛ, ХОРДЛОГЫН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ ТӨВИЙН ТҮВШНИЙ БҮРЭЛДЭХҮҮН




ХИМИЙН БОДИСЫН ОСОЛ, ХОРДЛОГЫН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ НЭГЖИЙН ТҮВШНИЙ БҮРЭЛДЭХҮҮН



БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ГАМШГИЙН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ ТӨВИЙН ТҮВШНИЙ БҮРЭЛДЭХҮҮН



БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ГАМШГИЙН ҮЕД АЖИЛЛАХ ТУТ-НЫ НЭГЖИЙН ТҮВШНИЙ БҮРЭЛДЭХҮҮН



**ХООЛ ХҮНСЭЭР ДАМЖИХ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, УС,
ХӨРС, АРЧДАСНЫ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, БАТАЛГААЖУУЛАХ ЛАБОРАТОРИ**

Лабораторийн нэр	Шинжилгээний үзүүлэлт	Аймгийн МХГ-ын лаборатори	НМХГ-ын Төв лабора- тори	Хилийн боомт дахь лабора- тори	ХАБҮЛЛ, Бататгах шинжил- гээ
Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн					
Нян судлал	Salmonella spp	+	+	+	+
	Staphylococcus aureus	+	+	+	+
	Bacillus cereus	+	+	+	+
	Listeria monocytogenes	+	+	-	+
	Escherichia coli	+	+	+	+
	Enterobacter (Cronobacter) sakazakii	-	+	-	+
	Micrococcus spp	+	+	-	+
	Clostridium perfringens	+	+	+	+
	Clostridium botulinum	+	+	+	+
	Pseudomonas aeruginosa	+	+	+	+
	Shigella	+	+	+	+
	Хөгц, мөөгөнцөр	+	+	+	+
	Proteus	+	+	+	+
	Campylobacter jejuni	-	+	-	+
	Escherichia coli 0157	+	+	-	+
Хими	Нитрит	+	+	+	+
	Будагч бодис E120, E122, E102, E151, E142, E129, E132, E131, E133, E160e, E121, E162, E107, E128, E141, E102, E110, E123, E129, E133, E124, E104, E127, E120, E128	Илрүүлэх аргаар шинжилгээ хийнэ.	+	Илрүүлэх аргаар шинжилгээ хийнэ.	+
	Бензойны хүчил, бензойны хүчлийн натрийн давс	-	+	-	+
	Сорбины хүчил, сорбины хүчлийн калийн давс	-	+	-	+
Хор судлал	Афлатоксин B1, B2	Нимгэн үет хроматографийн аргаар чанарын анализ буюу илрүүлэх шинжилгээг хийнэ.	+	+	+
	Деоксиниваленол		+	+	+
	Афлатоксин G1, G2		+	+	+
	Афлатоксин M1		+	+	+
	Нийлбэр афлатоксин		+	+	+
	Дезоксиниваленол		+	+	+
	Зеараленон		+	+	+
	Фумонизин		+	+	+
	Охратоксин		+	+	+
	T-2 токсин		+	+	+
	Бензо-А-прейн		+	+	+
	Меламин		+	+	+
	Хар тугалга	-	+	-	+
	Кадми	-	+	-	+
	Зэс	-	+	-	+
	Цайр	-	+	-	+
	Төмөр	-	+	-	+
	Никель	-	-	-	+
	Кобальт	-	-	-	+
	Хром	-	-	-	+
	Манган	-	-	-	+
	Хүнцэл	-	-	-	+
	Сурьма	-	-	-	+

	Селен	-	-	-	+
Цацраг	Нийлбэр гамма идэвх	-	-	-	+
	K-40 изотопын идэвх	-	-	-	+
	Cs-137 изотопын идэвх	-	-	-	+
	Cs-134 изотопын идэвх	-	-	-	+
	Хлорорганик пестицид	Хлорорганик болон фосфор органик пестицидийг чанарын анализын аргаар илрүүлэх шинжилгээг хийнэ.	+	Хлорорганик болон фосфор органик пестицидийг чанарын анализын аргаар илрүүлэх шинжилгээг хийнэ.	+
Линдан	+		+		
2,4-Д	+		+		
4,4-ДДТ	+		+		
Гексахлорбензол	+		+		
Дильдрин	+		+		
Альдрин	+		+		
Альфа-ГХЦГ	+		+		
Бета-ГХЦГ	+		+		
Перметрин	+		+		
Клоквинтосет	+		+		
Цигалотрин	+		+		
Циперметрин	+		+		
Ципроконазол	+		+		
Дифеноконазол	+		+		
Феноксапроп-этил	+		+		
Фенвалерат	+		+		
Имазалил	+		+		
Тебюконазол	+		+		
Триаклимефон	+		+		
Трихлорфон	+		+		
Фосфорорганик пестицид	+		+		
Карбофоса	+		+		
Паратион метил	+		+		
Дельтаметрин	+		+		
Циперметрин	+		+		
Диазинон	+		+		
Прометрин	+		+		
Дельтаметрина	+		+		
Прометрина	+		+		
Pirimiphros	+	+			
Гадаад орчны шинжилгээ					
Хөрс	Нянгийн нийт тоо	+	+	+	+
	Эмгэгтөрөгч	+	+	+	+
	Гэдэсний савханцар	+	+	+	+
	Clostridium perfringens	+	+	+	+
	Протеус	+	+	+	+
	Мөнгөн ус	-	+	-	+
Ус	Савханцар	+	+	+	+
	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтаст шүүлтүүр/	+	+	+	+
	Сульфид задлах агааргүйтэн (шингэн тэжээлт орчинд баяжуулах)	+	+	+	+
	Бактерийн ерөнхий тоо	+	+	+	+
	Гэдэсний бүлгийн эмгэгтөрөгч	+	+	+	+
	Хар тугалга	-	+	-	+
	Кадми	-	+	-	+
	Зэс	-	+	-	+
	Цайр	-	+	-	+
	Никель	-	-	-	+
	Кобальт	-	-	-	+
	Мөнгөн ус	-	+	-	+
	Цианид	-	-	-	+
	Хром	-	-	-	+
	Манган	-	-	-	+
	Селен	-	-	-	+
	Хүнцэл	-	-	-	+
	Сурьма	-	-	-	+

	Хатуулга	+	+	+	+
	Хлорид	+	+	+	+
	Нитрит	+	+	+	+
	Нитрат	+	+	+	+
	Нийт төмөр	+	+	+	+
	pH	+	+	+	+
	Сульфат	+	+	+	+
	Фтор	+	+	+	+
	Исэлдэх чанар	+	+	+	+
	Хуурай үлдэгдэл	+	+	+	+
	Катионууд /натри, лити, кали/	-	-	-	+
	Анионууд /фтор, хлор, фосфат/	-	-	-	+
Арчдас	Бактери	+	+	+	+
	Хөгц, мөөгөнцөр	+	+	+	+

**Хилийн нэвтрэх цэгийн тусгаарлах өрөөний зохион байгуулалт,
шаардлага, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал
халдваргүйтгэлийн бодис, эмийн жагсаалт**

1. Хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтэс нь өвчний сэжигтэй зорчигчийг тусгаарлах өрөө нь халдвар хамгааллын дэглэмийн шаардлага хангасан, зураг 1-д заасан ерөнхий зохион байгуулалттай байна.

2. Тусгаарлах өрөө нь хөл хөдөлгөөнөөс зайдуу, гадагш нэвт гарах хаалгатай, агаарын сөрөг даралттай, халдвараас сэргийлэх дэглэм мөрдөх нөхцөлийг хангасан байна.

2.1. Тусгаарлах өрөө нь халдвартай, завсрын, халдваргүй гэсэн 3 бүстэй, байгалийн болон зохиомол гэрэлтүүлгээр хангагдсан байна.

2.1.1. Халдвартай бүс /улаан/ буюу сэжигтэй зорчигчийн өрөө нь агаарын сөрөг даралттай, зориулалтын ор, ширээ сандлаар хангагдсан, дотроо бие засах суултуур, шүршүүр, гар угаалтуур байршуулсан, эрүүл мэндийн ажилтныг дуудах дохиололтой, гадагш харьцсан хаалгатай байх ба өвчтний зөөврийн орыг саадгүй нэвтрүүлэх хэмжээтэй, босгогүй байна. Хаалганы гадна халдвартайг илтгэх тэмдэглэгээтэй, байнга хаалттай байлгана.

2.1.2. Завсрын бүс /шар/ буюу дамжин өнгөрөх өрөөнд хувийн хамгаалах хувцсыг өмсөх, тайлах, халдваргүйжүүлэлт хийх, гар угаах нөхцөлөөр хангагдсан, аюултай хог хаягдлын уут, сав байршуулсан байна.


2.1.3. Халдваргүй бүс /ногоон/ нь эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчийн сэжигтэй зорчигчоос эрүүл мэндийн мэдүүлэг авах, халуун хэмжих, гар ариутгах нөхцөлөөр хангагдсан, эм, хувийн хамгаалах хувцас хадгалах зориулалтын шүүгээтэй байна.

2.2. Тусгаарлах өрөөний унд, ахуйн хэрэглээний ус нь стандартын шаардлагад нийцсэн байна.

2.3. Аюултай хог хаягдлыг холбогдох журам, зааврын дагуу цуглуулж устгана.

Тусгаарлах өрөөний ерөнхий зохион байгуулалт

Зураг 1



Тусгаарлах өрөөнд шаардлагатай тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалт

№	Нэр	Хэмжих нэгж	Зориулалт
1.Тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл/жишиг/			
1.1	Эмнэлгийн ор	ширхэг	Сэжигтэй зорчигчийг улаан бүсэд хэвтүүлэх
1.2	Амьсгалын аппарат /амбу/	ширхэг	Амьсгал дэмжих
1.3	Зөөврийн автоклав	ширхэг	Халдвартай материал ариутгах
1.4	Зөөврийн нян устгах гэрэл	ширхэг	Ариун орчин бүрдүүлэх
1.5	Зөөврийн изолятор	ширхэг	Голомтын гадна бүсэд хавьтагсдыг тусгаарлах
1.6	Бикс иж бүрдлийн хамт /пинцет, шархны наалт, тариур гэх мэт/	ширхэг	Тусламж үйлчилгээнд хэрэглэх эмнэлгийн хэрэгсэл битүүмжлэн хадгалах
1.7	Зөөврийн автомакс	ширхэг	Байнгын болон голомтын халдваргүйжүүлэлтэд
1.8	Чагнуур, даралтын аппарат	ширхэг	Уушги, зүрх чагнах, цусны даралт үзэх
1.9	Хэл дарагч	ширхэг	Үзлэгт хэрэглэх
1.10	Хөвөн, бинт	ширхэг	Шархны боолт, цус тогтоох гэх мэт анхны тусламж үзүүлэхэд
1.11	Чангалуур	ширхэг	Цус алдах үед анхан шатны тусламж үзүүлэх
1.12	Дуслын штатив	ширхэг	Дуслын тариа хийхэд
1.13	Зүү тариурын хаягдал цуглуулах нэг удаагийн сав /аюулгүй хайрцаг/	ширхэг	Хэрэглэсэн тариурыг аюулгүй түр хадгалах
1.14	Аюултай хог хаягдал цуглуулах уут /шар, улаан өнгийн/	ширхэг	Халдвартай материалыг аюулгүй хадгалах
1.15	Халуун хэмжигч /дигитал , халууны шил/	ширхэг	Биеийн халуун хэмжих
1.16	Зөөврийн дамнуурга	ширхэг	Өвчтнийг зөөвөрлөх
1.17	Шарил битүүмжлэх уут	ширхэг	Халдвараас сэргийлж, аюулгүй тээвэрлэх
1.18	Шинжлэгдэхүүн авах ариун уут, сав	ширхэг	Бөөлжис болон бусад биологийн шингэн, хоол хүнсний дээж авах
1.19	Хөргөгч	ширхэг	Өвчтнөөс авсан шинжлэгдэхүүн болон эм, тариа, оношлуур хадгалах
1.20	Хөлдөөгч	ширхэг	Мөс болон бусад зарим хөлдөөх шаардлагатай материал хадгалах
1.21	Ханын шүүгээ	ширхэг	Эм тариа, эмнэлгийн хэрэгсэл хадгалах
2. Хувийн хамгаалах хэрэгсэл /жишиг/			
2.1	Нэг удаагийн хамгаалах хэрэгсэл /халад, хормогч,комбинзон, малгай/	иж бүрдэл	Урьдчилан сэргийлэх болон голомтод
2.2	№ 95 болон түүнтэй адилтгах шүүлтүүртэй амны хаалт	ширхэг	Урьдчилан сэргийлэх болон амьсгалын замын халдварын үед
2.3	Нэг удаагийн амны хаалт	ширхэг	Урьдчилан сэргийлэх болон голомтод
2.4	Нэг удаагийн бээлий	ширхэг	Урьдчилан сэргийлэх болон голомтод
2.5	Нүдний шил	ширхэг	Урьдчилан сэргийлэх болон голомтод
2.6	Нүүрний хаалт	ширхэг	Урьдчилан сэргийлэх болон голомтод
2.7	Усны гутал	хос ширхэг	Голомтод
2.8	Богино долгионы станц	ширхэг	Мэдээг шуурхай дамжуулах
3. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис /жишиг/			
3.1	Хлорлог бодисууд//кальцийн гипохлорид, жавелион, клорсепт гэх мэт/	шахмал нунтаг	Байнгын болон эцсийн халдваргүйжүүлэлтэд
3.2	Иодлог бодисууд/тамедин г.м/	шингэн, нунтаг	Байнгын болон эцсийн халдваргүйжүүлэлтэд
3.3	Исэлдүүлэгчид/устөрөгчийн хэт исэл, секусепт г.м/	шингэн, нунтаг	Байнгын болон эцсийн халдваргүйжүүлэлтэд
3.4	Дөрөвдөгч аммонийн нэгдлүүд/дезэфект, кует	шингэн, нунтаг	Байнгын болон эцсийн халдваргүйжүүлэлтэд

	нэгдлүүд/дезэфект, кует санитайзер г.м/	нунтаг	
3.5	Спирттэй нэгдлүүд/санитол, спирт70%, 96% г.м/	шингэн	Байнгын болон эцсийн халдваргүйжүүлэлт, гар халдваргүйжүүлэлтэд

Тусгаарлах өрөөнд яаралтай тусламжид шаардлагатай эмийн жагсаалт

№	Эмийн нэр, тун хэмжээ	Эмийн хэлбэр	
1	Ацикловир 200мг №10	Шахмал	
2	Викасол 2мл	Тарилгын уусмал	Шахмал
3	Валидол №10	Шахмал	
5	Дротаверин 40мг-2мл	Тарилгын уусмал	Шахмал
6	Дифенгидрамин 1%-1мл	Тарилгын уусмал	Шахмал
7	Диклофенак натри 100мг-№10	Шахмал	Тарилгын уусмал
8	Дибазол 1%-5мл	Тарилгын уусмал	Шахмал
9	Дигоксин 0,025%-1мл	Тарилгын уусмал	Шахмал
10	Иод 10мл	Уусмал	
11	Кордиамин 25%-1мл	Тарилгын уусмал	
12	Кальци глюканат 10%-10мл	Тарилгын уусмал	Шахмал
13	Лидокаин гидрохлорид 2%-2мл	Тарилгын уусмал	
14	Магни сульфат 25%-10мл	Тарилгын уусмал	
15	Метомизол натри 50%-2мл	Тарилгын уусмал	Шахмал
16	Метокпрамид 5мг-2мл	Тарилгын уусмал	Шахмал
17	Натри хлорид 0,9%-400 мл	Тарилгын уусмал	
18	Новокаин гидрохлорид 0,5%-2мл	Тарилгын уусмал	
19	Нитроглицерин 5мкг	Шахмал	
20	Парацетамол 500мг-№10	шахмал	
21	Преднизолон 30мкг-2мл	Тарилгын уусмал	Шахмал
22	Сальбутамол 100мкг	Цацлага	
23	Спирт денатурат 76%-100мл	Уусмал	
24	Тамедин 0,7%-100мл	Уусмал	
25	Тамифлю 75мг	Шахмал	
26	Фуросемид 1%-2мл	Тарилгын уусмал	Шахмал
27	Шингэн сэлбэх давс 200мл, 1л-т найруулахаар	Нунтаг	

Тайлбар: ЭМС-ын 2005 оны 297 дугаар тушаалаар батлагдсан эмнэлгийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эмийн жагсаалтыг үндэслэв.

ЗОРЧИГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДҮҮЛЭГ
/Health declaration form of passengers /



1. Овог (Surname).....
2. Нэр (Given name).....
3. Хүйс(Sex)
Эр (Male) ☐ Эм (Female) ☐
4. Иргэншил (Nationality).....
5. Төрсөн он, сар, өдөр (Date of birth)
6. Паспортын дугаар (Passport).....
7. Регистрийн дугаар (Personal ID №).....
8. Аялал (онгоц/галт тэрэг/ машин)-ын дугаар (Travel / flight/ train/ car №).....
9. Суудлын дугаар (Seat №).....
10. Монгол Улсад байх хаяг (Adress in Mongolia).....
11. Утасны дугаар (Phone №).....
12. Шаардлагатай үед холбоо барих хүний нэр, утасны дугаар (Name of person and phone № in emergency situation).....
13. Сүүлийн 14-21 хоногт зорчсон улс? (Countries visited in last 14-21 days?).....
14. Танд дараахь шинж тэмдэг илэрч байвал + тэмдэг тавина уу? (Please put +after the symptom if you have any?)

№	Илэрсэн шинж тэмдэг (Symptom)	+ -	№	Илэрсэн шинж тэмдэг (Symptom)	+ -
1	38 ⁰ C-ээс дээш халуурах (Fever above 38 ⁰ C)		8	Хэвлийгээр өвдөх (Abdominal stomach pain)	
2	Толгой өвдөх (Headache)		9	Бөөлжих (Vomiting)	
3	Булчингаар өвдөх (Muscle pain)		10	Суулгах (Diarhea)	
4	Нүд улайх (Red eyes)		11	Чичрэх (Ague)	
5	Хоолой өвдөх (Sore throat)		12	Арьсны тууралт (Skin rash)	
6	Ханиалгах (Coughing)		13	Унтаа байдалд байх (Lethargy)	
7	Хамраас нус гоожих (Running nose)		14	Бие сулрах (Weakness)	

15. Сүүлийн 14-21 хоногт халдварт өвчний сэжигтэй болон өвчтэй хүнтэй ойр байсан уу?
(Have you been close contact with suspected case or ill person in the last 14-21 days?)

Тийм (Yes) ☐ Үгүй (No) ☐

16. Сүүлийн 7-14 хоногийн хугацаанд эм /антибиотик/ хэрэглэсэн үү? (Take antibiotic treatment in the last 7-14 days?) Тийм (Yes) ☐ Үгүй (No) ☐

17. Мэдүүлэг авсан Он сар өдөр цаг минут
(year) (month) (day) (hour) (minute)

18. Зорчигчийн гарын үсэг (Passenger's signature).....

19. Улсын /ахлах/ байцаагчийн гарын үсэг (Inspector's /senior/ signature).....